


# ТАЙЛАН 2019/2020



Хараат бус

Чанар

Үр нөлөө



# АГУУЛГА

1	<b>Бидний үзүүлдэг үйлчилгээ</b> .....	2
2	<b>Өмнөх үг</b> .....	3
3	<b>Бидний тухай</b> .....	4
4	<b>IRIM тоогоор</b> .....	5
5	<b>2019 оны онцлох үйл явдлын товчоо</b> .....	6
6	<b>Дотоод төслүүд</b> .....	10
	1. Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал .....	11
	2. Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа .....	15
7	<b>Хэрэгжүүлсэн төслүүд</b> .....	17
	3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ, эрсдэлд суурилсан дотоод аудитынтогтолцоо бий болгох төсөл .....	17
	4. Хотын засаглалыг сайжруулах төсөл (ХЗСТ)-ийн дунд шатны үнэлгээ .....	22
	5. Төрийн бодлого үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа .....	25
	6. Монголчуудын амьдралын хэв маяг болон соёлын судалгаа I-III .....	29
	7. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа .....	32
	8. “Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь” төслийн судалгаа.....	34
	9. “Залуусын тогтвортой ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн үр дүнгийн үнэлгээ... ..	37
	10. Зорилтот бүлгийн иргэдийн төрийн үйлчилгээний хүртээмжийн жендерийн үнэлгээ ..	40
	11. Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний сургалт .....	45
	12. Төрийн байгууллагын цахим засаглалыг сайжруулахад иргэний нийгмийн байгууллагуудыг (ИНБ) чадавхжуулах төсөл .....	48
	13. Монгол Улсын засгийн газар, НҮБ-ын хүүхдийн сангийн хамтарсан 2012-2016, 2017-2021 онуудын улс орны хөтөлбөрийн боловсролын үр дүнгийн хамран сургалтын бүрэлдэхүүн хэсэгт хийх үнэлгээний төсөл .....	52
	14. Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтийг үнэлэх үндэсний үнэлгээний тогтолцоо ба чадавхын тойм судалгаа (кейс судалгаа) .....	55
	15. Органик хөдөө аж ахуйг дэмжих төслийн суурь судалгаа .....	59
8	<b>Хэрэгжиж буй төслүүд</b> .....	56
	16. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах төсөл .....	62
	17. Дэд бүтцийн бүтээн байгуулалтад талуудын ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэх говийн загвар: Монголын туршлагыг төв азид .....	65
	18. Улаанбаатар хот руу чиглэсэн дотоод шилжих хөдөлгөөний бүртгэлийн хязгаарлалт болон шилжин ирэгсдийн эмзэг байдалд үзүүлсэн үр нөлөөллийн судалгаа .....	68
	19. “Амьсгалах эрх” төслийн хэрэгжилтийн үнэлгээ .....	70
	20. “Гүүд нейборс монгол” ОУТББ-ын байгууллагын орчны шинжилгээ.....	73
	21. Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төслийн эцсийн шатны үнэлгээ .....	75

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Дэлхийн жишигт нийцсэн, хараат бус судалгаа зөвлөх үйлчилгээ хүргэдэг Монголын туршлагад тулгуурласан мэдлэгийн төв болно.

## ЧАНАРЫН БОДЛОГО

Олон улсын стандарт, захиалагчийн хэрэгцээнд нийцсэн, хараат бус судалгааны үйлчилгээ үзүүлдэг, тогтвортой хөгжих байгууллага байна.

## БИДНИЙ ҮЗҮҮЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

ТУРШЛАГА:

**СУДАЛГАА** - Бид мэргэжлийн, шинжлэх ухаанч арга зүйгээр олон салбар хамарсан судалгааны ажлын туршлагатай. Тоон ба чанарын аргыг ашиглан шинэлэг, салбар хоорондын судалгааны төслийн дизайныг боловсруулж, хэрэгжүүлж ирсэн. Судалгааны мэдээллийн найдвартай байдалд чанарын хяналт тавьж, үр дүнг сүүлийн үеийн судалгааны мэдээлэл боловсруулах программ дээр гүнзгийрүүлсэн дүн шинжилгээ хийн үр дүнг боловсруулж байна.

103  
ТӨСӨЛ

**ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ** - Хяналт, үнэлгээний ажлууд манай байгууллагын гүйцэтгэж буй ажлын гуравны нэг орчим хувийг эзэлдэг. Бид Засгийн газар болон Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрүүдэд хараат бус, хөндлөнгийн шинжилгээ хийж, баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу баримт нотолгоонд суурилсан дүгнэлт гаргахыг эрмэлздэг.

70  
ТӨСӨЛ

Манай байгууллага нь Монголын Үнэлгээний Сүлжээг санаачлагчдын нэг бөгөөд гишүүдийн хамтаар Үндэсний Үнэлгээний стандартыг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

**СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ** - Бид сургалт хэлэлцүүлэг зохион байгуулахдаа олон төрлийн аргачлал, арга зүйг ашиглахаас гадна өөрсдийн туршлагаараа байнга баяжуулж, шинэчилдэг. Сургалтууд нь төсвийн нээлттэй байдал, иргэдийн оролцоо, байгууллагын чадавхийг бэхжүүлэх зэрэг олон сэдвийг хамардаг. Бид сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулахдаа оролцооны, интерактив аргачлал ашигладаг ба зохион байгуулалт, оролцогчдын хэрэгцээний үнэлгээ, сургалтын материал, модулийн боловсруулалт, баримтжуулалт (зураг, тэмдэглэл гэх мэт) болон сургалт бүрийн төгсгөлд сэтгэл ханамжийн судалгаа хийж цаашид сайжруулах боломж, үр дүнг үнэлдэг.

20  
ТӨСӨЛ

**ТӨСЛИЙН МЕНЕЖМЕНТ** - Манай байгууллагын хэрэгжүүлдэг төслүүд судалгаагаар хязгаарлагддаггүй. Бид бодлогын түвшний шийдвэр гаргагчдад нөлөөлөх төрөл бүрийн арга зүйн зөвлөх үйлчилгээ болон нөлөөллийн төслүүд төлөвлөн, хэрэгжүүлдэг. Үүнд:

- Хөгжлийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх, арга зүй, санал зөвлөмж дэвшүүлэх;
- Байгууллагын дотоод гадаад орчны шинжилгээ хийх, чадавхжуулах стратеги боловсруулах зэрэг үйлчилгээнүүд үзүүлдэг.

23  
ТӨСӨЛ



Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, IRIM-ийн Ерөнхийлөгч  
Х.Бэхбат



Гүйцэтгэх захирал  
Л.Цэлмэгсайхан

Дэлхийн улс орнууд өдөр ирэх тусам нэг нэгнээсэ хамааралтай аж төрж, зэрэгцэн оршиж байгаа, хэн нэгэнд маань үүссэн асуудал бид бүгдэд хамаатай болохыг КОВИД-19 хэмээх шинэ вирусээр үүсгэгдсэн цар тахал бидэнд харууллаа. Энэ шинэ сорилт нь улс орнууд дундын эрх ашгаа ойлгох, өөр хоорондоо мэдлэг, туршлагаа хуваалцах, хамтран ажиллах, харилцан туслалцах замаар нэгдмэл байх нь өнөөдрийн хүндрэлийг давах, маргаашийн дэлхий ертөнц ямар байхыг тодорхойлох болж байна. Өрнөж буй үйл явцыг бүхэл зургаар нь харвал, нөхцөл байдал тодорхойгүй болохын хэрээр улс орнуудад засаглалын хямрал нүүрлэх, нийгмийн тэгш бус байдал, ядуурал даамжрах, улмаар хөгжлийн өнөөгийн цэгээс ухрах аюултай.

Түүнчлэн, Монгол Улс өмнөхөөсөө илүү эв нэгдэлтэй, итгэлцэлтэй байхын сацуу тодорхойгүй нөхцөл байдалд хурдтай, шийдэмгий алхмууд авах нь хүнд хэцүү цаг үеийг хохирол багатайгаар даван туулахад чухал байна. Үүнтэй зэрэгцэн, эдийн засаг, нийгмийг хамарсан айсуу хямрал, засаглалын сорилттой цаг үед хүний эрхийг хамгаалах, ардчилал, сайн засаглалыг бэхжүүлэх, нийгмийн тэгш оролцоот хөгжлийг таслалгүй хангах нь чухлаар тавигдаж байна.

Мэргэшсэн судалгааны байгууллагын хувьд, бид энэхүү ээдрээт цаг үед шийдвэр гаргагчдыг хараат бус, бодит нотолгоо, мэдээллээр хангах замаар хөгжлийн шийдвэр гаргалтыг илүү оновчтой, хүртээмжтэй, тулхтай болгоход хувь нэмрээ оруулах ёстойг эргэцүүлж, ухамсарлаж байна. Тиймээс, бид өөрсдийн санаачилсан нэрийн судалгаануудыг 2020 онд таслалгүй санхүүжүүлэн үргэлжлүүлж, гарсан үр дүнг бодит үр нөлөөг бий болгоход чиглүүлж ажиллах болно.

Онцлон дурдвал, нэн тэргүүнд, улсын хөгжлийг үнэлдэг уламжлалт эдийн засгийн хэмжүүрээс гадна нийгмийн байдлыг илтгэсэн хэмжүүр, үзүүлэлтийг ашиглах оролдлого болох “Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”-ны арга зүйг чанарын судалгаагаар баяжуулж, илүү нарийвчилсан үр дүн бүхий тайлан 2020 онд гаргахыг зорьж байна. Энэхүү судалгаа нь зөвхөн материаллаг баялаг бүхий нийгэм биш харин иргэд нь харилцан итгэдэг, хамтран ажилладаг, харьцангуй тэгш, аз жаргалтай, сайн сайхан нийгмийг цогцлооход мэдлэгийн нэмэр болно гэж итгэж байна. Цаашлаад, орчин үеийн мэдээлэл харилцааны технологийг ашиглан төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хэмжих “Цахим ил бод байдлын индекс”-ийн анхны туршилтыг 2019 онд Монгол, Киргиз улсад амжилттай хийсэн үр дүнгээ 2020 онд илүү бүс нутгийн санаачилга болгохоор чиглэж ажиллаж байна.

Энэ дашрамд, бидний өнөөг хүртэл өсөж хөгжсөн түүх, 12 жилийн тасралтгүй үйл ажиллагаа нь бидний үнэт зүйл, мэргэжлийн ур чадварт итгэл хүлээлгэсэн харилцагч байгууллагууд, салбар тус бүртээ эерэг өөрчлөлтийг авчрах чин эрмэлзэлтэй судлаачид, зөвлөхүүдийн хамтын хүчин чармайлтын үр дүн юм.

Бид уламжлал ёсоор энэхүү тайлангаа Монголын хөгжлийн асуудлаар сонирхогч хэн бүхэнд IRIM судалгааны хүрээлэнгийн 2019 онд хэрэгжүүлсэн төслүүд, тэдгээрийн үр дүнгийн талаар мэдээлэл болгох үүднээс бэлтгэн хүргэж байна.

Ойлголцол, итгэлцэл, хамтын зүтгэл өөрчлөлтийг авчрах нь дамжиггүй. Илүү сайхан ирээдүйн төлөөх та бүхний үйлс улам өөдрөг байг.

## БИДНИЙ ТУХАЙ



IRIM судалгааны хүрээлэн нь 2008 онд дөрвөн хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагааныхаа гарааг эхэлж байсан бол өнөөгийн байдлаар нийт 25 үндсэн ажилтантай, 300 гаруй үндэсний болон олон улсын гэрээт зөвлөх, судлаачдын багтай үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

Бид төслийн удирдлага, сургалт, судалгаа, үнэлгээний чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд бодитой хувь нэмрээ оруулахыг зорьж ажилладаг.

Энэ хугацаанд бид өөрийн орны онцлогийг тусгасан, үр дүнг чухалчилсан, үйлчлүүлэгч төвтэй төслийн менежментийн шийдлүүдийг санал болгохоос гадна нотолгоонд суурилсан **чанартай** мэдээлэл бий болгох, **хараат бус**, хөндлөнгийн байр суурийг хадгалах, нийгэмд үзүүлэх **үр нөлөөгөө** дээшлүүлэх зарчмыг үргэлж баримталсаар ирсэн.

Манай байгууллагын гүйцэтгэдэг зөвлөх үйлчилгээ, судалгааны ажил нь өргөн хүрээний нийгмийн асуудлуудыг хамардаг, түүн дотроо засаглал, боловсрол, хөдөлмөрийн зах зээл болон уул уурхай, байгаль орчны салбарт илүүтэй төвлөрдөг.

Улмаар бидний үйл ажиллагааны цар хүрээ өргөжин тэлж 2013 онд MIRIM (Marketing and Innovation Research Institute of Mongolia) Консалтант компанийг үүсгэн байгуулж маркетинг, инновацын судалгааны чиглэлээр мөн үйл ажиллагаа явуулж байна.



## 2019 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧОО

IRIM судалгааны хүрээлэн Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгааны тойм тайланг хэвлэн гаргаж, олон нийтэд түгээлээ.

1 сар



2 сар

Бүгд Найрамдах Казахстан улсын Алматы хотноо зохион байгуулагдсан Төв Азийн бүсийн 'Innovation for Change' хөтөлбөрийн уулзалт, сургалтад оролцлоо.

Олон улсын хандивын Give2Asia сүлжээнд нэгдэн орлоо.

3 сар



4 сар

IRIM судалгааны хүрээлэн байгуулагдсаны 11 жилийн ойн баяраар "Хараат бус-Чанар-Үр нөлөө" сэдвийн хүрээнд хурал зохион байгуулав. Мөн уламжлал ёсоор салбар дундын спортын арга хэмжээ зохион байгуулж "Ид шидийн орон 2" төсөлд хандивлалаа.

IRIM судалгааны хүрээлэн Австрали улсад зохион байгуулагдсан "Нөлөөллийн үнэлгээний Олон Улсын Холбооны хурал"-д оролцлоо. Тус хуралд "Нийгмийн асуудлыг шинжлэх ухаанд эргэн тавих нь: Нийгмийн нөлөөллийн үнэлгээний чанарын эргэн тойронд" илтгэл тавив.

5 сар



6 сар



Австралийн сайн дурын ажилтан Майкл Батчелор нэг жилийн хугацаатай төслийн менежментийн ажилтнаар ажиллаж эхэллээ. Мөн 2019 онд Орос улсаас дадлагажигч Алекс Виллиамс, АНУ-ын Фулбрайт хөтөлбөрөөр судлаач Бриттани Бондай нарыг хүлээн авч хамтран ажиллав.

IRIM судалгааны хүрээлэн нийгмийн хариуцлагынхаа хүрээнд хүүхэд хамгааллын бодлогоо олон улсын стандартын дагуу шинэчлэн боловсрууллаа. Мөн Киргиз улсын төрийн байгууллагын цахим засаглалын индексийг тодорхойлохоор тус улсад ажиллаж, сургалт зохион байгууллаа.

7 сар



8 сар



"Төрийн байгууллагын цахим засаглалын ил тод байдлын индекс"-ийн нээлтийн арга хэмжээг Киргиз улсад зохион байгуулж, Монгол болон Киргиз Улсын төрийн байгууллагын цахим ил тод байдлын үр дүнг Төв Азийн долоон орны төлөөллүүдэд болон Киргиз Улсын төрийн болон ОУБ-уудад танилцуулав.

IRIM судалгааны хүрээлэнгийн ТУЗ-ийн гишүүн А.Долгион Олон Улсын Reagen-Fascell Democracy Fellowship хөтөлбөрт амжилттай шалгарч АНУ-ын Вашингтон хотыг зорилго. Мөн манай байгууллагын уламжлалт 'судлаач оюутан' хөтөлбөр зарлагдаж, нийт 12 оюутан амжилттай төгсөөд байна.

9 сар



10 сар



IRIM судалгааны хүрээлэнгийн төлөөлөл Олон улсын Валютын сан, Дэлхийн банкны жилийн уулзалт болон Тайвань улсын нийслэл Тайпэй хотод болсон ОУ-ын Нийгмийн сайн сайхан байдлын судалгааны консорциум-ын зургаа дахь удаагийн хуралд оролцлоо.

Тайландын Бангкок хотноо Innovation for Change даян дэлхийн санаачилгын сүлжээний бүсийн нэгдсэн уулзалтад Гүйцэтгэх захирал Ц.Батсүгар оролцлоо.

11 сар



12 сар



IRIM судалгааны хүрээлэн жилийн уулзалтаа хамтран ажилладаг түнш байгууллагуудынхаа хүрээнд зохион байгуулж өөрсдийн санаачлан хэрэгжүүлж буй "Төрийн байгууллагын цахим засаглалын ид тод байдлын индекс"-ын үр дүнг танилцуулж, олон нийтэд нээлттэй хүргэв.



# 2019 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД

IRIM судалгааны хүрээлэн Нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад зориулан “Судалгааны арга зүй”, “MS Excel програмын гарын авлага” боловсрууллаа.

1 сар



‘Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020-2026)’ боловсруулах төслийн хүрээнд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав.

2 сар



Архангай аймгийн Булган сумын Ойт хээрийн бүсийн ‘Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын оршин суугчдын нийгэм-эдийн засгийн суурь судалгаа’-г гүйцэтгэлээ.

3 сар



‘Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ, эрсдэлд суурилсан дотоод аудитын тогтолцоог бий болгох’ төслийг хэрэгжүүлж эхлэв.

4 сар



Нөлөөллийн үнэлгээний олон улсын холбооны зөвшөөрлөөр ‘Нийгмийн нөлөөллийн үнэлгээний гарын авлага’ орчуулах ажлыг эхлүүлэв.

5 сар



IRIM судалгааны хүрээлэн 10 орчим жил хэрэгжүүлж буй “Төрийн байгууллагын цахим мониторинг”-ийн арга зүй, аргачлалыг шинэчлэн сайжруулж “Төрийн байгууллагын цахим засаглалын ил тод байдлын индекс”-ийг боловсрууллаа.

6 сар



‘Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны үнэлгээ’-г баруун бүсийн аймгуудад гүйцэтгэлээ.

7 сар



“Төрийн байгууллагын цахим засаглалын ил тод байдлын индекс”-ийг бусад орнуудад хэрхэн гүйцэтгэх талаарх сургалтыг Киргиз улсад зохион байгуулав. Тус сургалтанд нийт Төв Азийн долоон орны ИНБ-уудын төлөөллийг урьж оролцууллаа.

8 сар



‘Тэгш хамруулах боловсролын дэмжих нь’ судалгааны ажилд 5296 өрхийн 9555 хүүхдийг хамруулан амжилттай хэрэгжүүлж дууслаа.

9 сар



‘Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтийг үнэлэх үндэсний үнэлгээний тогтолцоо ба чадавхийн судалгаа’-г гүйцэтгэлээ.

10 сар



‘Зорилтот бүлгийн иргэдийн төрийн үйлчилгээний хүртээмжийн жендерийн үнэлгээ’-г гүйцэтгэж нийслэлийн холбогдох байгууллагын ажилчдад танилцууллаа.

11 сар



Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн төрийн бодлого үйлчилгээний талаарх ‘Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа’-ны тайланг боловсруулан гаргалаа.

12 сар



## 2019 ОНЫ ОНЦЛОХ МЭДЭЭ

### ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ ЖИЛИЙН ХҮЛЭЭН АВАЛТ-2019 ЗОХИОН БАЙГУУЛЛАА



IRIM судалгааны хүрээлэн нь 2015 оноос IRIM-ийн ерөнхийлөгч, элчин сайд Х.Бэхбатын ивээл дор “Жилийн хүлээн авалт”-г уламжлал болгон зохион байгуулсаар ирсэн. Хүлээн авалтаар тодорхой нэг сэдвийг сонгон авч тухайн асуудалд талуудын оролцоо, ойлголтыг нэмэгдүүлэхийг зорьдог онцлогтой.

Жилийн хүлээн авалт- 2019 арга хэмжээ нь “Цахим засаглалын ил тод байдлын индекс”

сэдвийн дор зохион байгуулагдсан. Засаглал нь манай байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдийн нэг бөгөөд бид төрийн үйл ажиллагааны зохистой тогтолцоо, хууль тогтоомж, хяналтын механизмуудыг болон төрийн үйлчилгээний шударга байдал, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоход анхаарч ажилладаг. Үүнтэй холбоотойгоор бид 2010 оноос хэрэгжүүлж байгаа “Төрийн байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт-ийн хэрэгжилтийг үнэлгээ”-ний туршлага дээрээ үндэслэн олон улсад харьцуулагдахуйц “Цахим засаглалын ил тод байдлын индекс”-ийг боловсруулж үр хүрэлцэн ирсэн зочдод дүнг танилцуулсан.

Цаашид тус индекс нь төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулах, ил тод нээлттэй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэхэд ихээхэн түлхэц болно гэдэгт бид итгэлтэй байна.

### МОНГОЛ ДАХЬ АЗ ЖАРГАЛД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ АЗИЙН БУСАД ОРНУУДАЙ ХАРЬЦУУЛАХ ЧАНАРЫН СУДАЛГААНЫ АЖЛЫГ ЭХЛҮҮЛЖ, ОУ-ЫН НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДЛЫН СУДАЛГААНЫ КОНСОРЦИУМЫН ЗУРГАА ДАХЬ ХУРАЛД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО.



Манай байгууллага нь ОУ-ын Нийгмийн сайн сайхан байдлын судалгааны консорциум (НССБСК)-ын гишүүн байгууллага болохынхоо хувьд нийгмийн сайн сайхан байдлын талаарх судалгаа, шинжилгээний ажлуудыг идэвхтэй гүйцэтгэж ирсэн. Өнгөрсөн 2019 онд Монголын нийгмийн сайн сайхан байдлын талаар судалгаа шинжилгээ хийсэн онцлох үйл ажиллагаанаас дурдвал:

- Азийн найман орны аз жаргалын талаарх чанарын судалгаа  
Монгол, Тайланд, Индонез, Филиппин, Вьетнам, Япон, Өмнөд Солонгос, Тайвань зэрэг НССБСК-ын гишүүн орны судлаачид хамтран зохион байгуулж буй олон улсын хэмжээнд харьцуулагдах чанарын судалгаа хэрэгжиж эхлээд байна. Судалгааны мэдээлэл цуглуулах ажил нь Улаанбаатар хотод 2019 оны 9 сараас эхэлсэн бөгөөд одоогоор бусад Азийн орнуудад шат дараатай гүйцэтгэгдэж байна. Уг судалгааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг хэрэгжиж буй төслүүд хэсгээс үзнэ үү.

- Зүүн болон Зүүн-Өмнөд Азийн орнуудын нийгмийн сайн сайхан байдлын харьцуулалт сэдэвт НССБСК-ын зургаадугаар хурал

Тайвань улсын нийслэл Тайпэй хотод 2019 оны 10 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан тус хуралд IRIM судалгааны хүрээлэнгийн менежерүүд болох Д.Түвшинтөгс, Л.Дашзэвэг нар 'Монголын ганц бие эцэг эхчүүдийн нийгмийн сайн сайхан байдал' сэдвээр илтгэл тавьж оролцлоо.

Тус хуралд Азийн нийт найман орны эрдэмтэн судлаачид оролцож, тухайн улс орнуудын нийгмийн сайн сайхан байдлын талаарх судалгааны үр дүнгүүдээ танилцуулав. Уг хурлаар танилцуулагдаж буй илтгэлүүд нь Зүүн ба Зүүн-Өмнөд Азийн орнуудын сонирхол татсан судалгааны асуудлыг шинэлэг, орчин үеийн аргачлалууд ашиглан хөндөн гаргадаг бөгөөд манай залуу судлаачдын хувьд мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх томоохон боломж гэж ойлгодог.

Уг консорциумд улсаа төлөөлөн ажиллаж байгаа байгууллага болохынхоо хувьд IRIM судалгааны хүрээлэн нь Монголын нийгмийн сайн сайхан байдлын талаарх судалгаа, шинжилгээний үйл ажиллагаанд томоохон үүрэг хүлээж ажилладаг ба сонирхсон талуудтай хамтын ажиллагаа өрнүүлэхэд нээлттэй.

## АВСТРАЛИ УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ОЛОН УЛСЫН ХУРАЛД ОРОЛЦЛОО



Олон улсын нөлөөллийн үнэлгээний мэргэжлийн байгууллага болох International Association for Impact Assessment (IAIA) 1980 онд байгуулагдаж, нөлөөллийн үнэлгээний чанар, хүлээн зөвшөөрөгдөлт, үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэлээр өнөөг хүртэл тасралтгүй ажиллаж байгаа билээ. Энэ жил тус холбооны 39 дахь конференс Австрали улсын Брисбен хотод 2019 оны 4 – 5 сард болж өнгөрлөө. Хуралд нийт 77 орны 885 оролцогч оролцож, 125 салбар хуралдаанд 481 илтгэл тавигдаж, 41 постер танилцуулагдлаа.

Энэ жилийн конференс “Нөлөөллийн үнэлгээний цаашдын хөгжил: Хувьслын замаар уу, хувьсгалын замаар уу” гэсэн үндсэн сэдвийн дор өрнөж, нөлөөллийн үнэлгээний үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд өмнө явж ирсэн онол парадигм, зохицуулалтыг үндсээр нь өөрчлөх үү, эсвэл одоогийн хөгжиж ирсэн практикаа илүү засаж

сайжруулах замаар жам ёсны хөгжлөөр замнах уу гэдэг асуултад хариулт эрсэн юм.

Уг конференсэд манай байгууллагын зөвлөх Л.Цэлмэгсайхан оролцож “Putting the ‘social’ back into science: Quality social impact assessment” сэдвээр нийгмийн нөлөөллийн үнэлгээг чанартай хийхэд олон улсын санхүүжүүлэгчдийн тавьдаг шаардлага нь хангалттай юу? гэсэн сэдвээр илтгэл хэлэлцүүлээ.

## IRIM СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН НЬ ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКС (DIGITAL TRANSPARENCY INDEX FOR GOVERNMENT ORGANISATIONS) КИРГИЗ УЛСЫН НИЙСЛЭЛ БИШКЕК ХОТНОО ТАНИЛЦУУЛЛАА



IRIM судалгааны хүрээлэн нь 2008 оноос хойш санаачлан хэрэгжүүлж буй “Төрийн байгууллагын цахим мониторинг”-ийн арга зүй, аргачлалыг шинэчлэн сайжруулж “Төрийн байгууллагын цахим засаглалын ил тод байдлын индекс”-ийг боловсрууллаа.



Тус индексийг турших, сайжруулах, албан ёсны нээлтийн арга хэмжээг Киргиз Улсын нийслэл Бишкек хотноо 7-8 сард зохион байгуулав. Индексийн гол онцлог бол зөвхөн мэдээллийн ил тод байдлыг үнэлэх бус, мэдээллийн ил тод байдлыг сайжруулахад шаардлагатай засаглал, хууль эрх зүй, иргэний нийгмийн идэвх оролцоо байгаа эсэхийг цогцоор нь харахаас гадна тухайн төрийн байгууллагууд мэдээллээ ил тод болгох чадавх, нөөц, механизм байгаа эсэхийг үнэлэх юм.

Индексийн олон улсын нээлтийн арга хэмжээнд улсын болон төрийн байгууллагууд, Төв Азийн долоон орны 30 гаруй төлөөлөл хүрэлцэн ирж Монгол болон Киргиз Улсын төрийн байгууллагын цахим ил тод байдлын үр дүнтэй танилцлаа. Мөн нээлтийн арга хэмжээний үер Төв Азийн орнуудын ил тод байдлыг сайжруулах стратегийн түншлэлийг байгуулахаа илэрхийлжээ.



### IRIM СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭНГИЙН ТӨЛӨӨЛӨЛ АНУ-ЫН ВАШИНГТОН ХОТОНД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САН, ДЭЛХИЙН БАНКНЫ ЖИЛИЙН УУЛЗАЛТАД ОРОЛЦЛОО



2019 оны 10 сард АНУ-ын Вашингтон хотноо зохион байгуулагдсан Олон улсын валютын сан (ОУВС), Дэлхийн банкны групп (WBG)-н жилийн уулзалтад IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх, ТУЗ-ийн гишүүн А.Долгион оролцлоо.


Тус хурлын үеэр улс орон бүрийн сангийн сайд, парламентын гишүүд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүд,

эрдэм шинжилгээний ажилтнууд дэлхийн эдийн засгийн төлөв байдал, ядуурлыг бууруулах, эдийн засгийн хөгжил, тусламжийн үр ашгийг дээшлүүлэх асуудлуудыг хэлэлцүүлдэг билээ.

Тус хурлын нэг хэсэг болох Иргэний нийгмийн бодлогын форумд, IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх, ТУЗ-ийн гишүүн А.Долгион байгууллагын бие даасан судалгаа болох Нийгмийн сайн сайхан байдлын судалгааны үр дүнгээс танилцуулж, нийгмийн хамгаалал, өрийн тогтвортой байдал, жендерийн тэгш байдал, иргэний нийгэм дэх оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулах асуудлаар бодлого боловсруулахад хувь нэмэр оруулахуйц судалгааны үр дүнгээс хуваалцсан юм.



## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ



ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН



2019

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД

### ЗАХИАЛАГЧИЙН НЭР

IRIM судалгааны хүрээлэн

### СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

IRIM судалгааны хүрээлэн 2010 оноос хойш төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг үнэлэх зорилгоор 'Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал' мониторинг судалгааг гүйцэтгэсээр ирсэн билээ. Уг хөндлөнгийн судалгаа нь төрийн байгууллагын цахим хуудасны мэдээллийн ил тод байдлыг (i) үйл ажиллагааны хувьд, (ii) хүний нөөцийн хувьд, (iii) төсөв санхүүгийн хувьд, (iv) худалдан авах ажиллагааны хувьд тус тус үнэлдэг. Төрийн байгууллагын цахим хуудсыг ил тод байдлаар нь эрэмбэлж, үзүүлэлт тус бүрээр жагсаах зорилготой.




2019

10-р сарын 03

2019

12-р сарын 04

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Судалгааны хүрээнд Улаанбаатар хот болон 21 аймгийн төрийн 72 байгууллагын цахим хуудсанд үнэлгээ хийсэн. Үүнд:

- Монгол Улсын Яам -13;
- Хэрэгжүүлэгч агентлаг -17;
- Тохируулагч агентлаг -10;
- Аймгуудыг засаг даргын тамгын газар - 21;
- Нийслэл, Дүүргийн засаг даргын тамгын газар – 11;
- Улсын Их Хурал болон түүний харьяа байгууллага - 9

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Бид 2019 онд уг үнэлгээг олон улсын түвшний индекс болгох зорилго өвөрлөн судалгааны аргагүйгээ шинэчилж, төрийн байгууллагын 'Цахим ил тод байдлын индекс'-ийг боловсрууллаа. Уг индексийн анхны туршилтыг Монгол болон Киргизстан улсад амжилттай гүйцэтгээд байна. Энэхүү тайланд Монгол Улсын төрийн байгууллагуудын цахим ил тод байдлыг шинэчилсэн аргагүйгээр үнэлж, гарсан үр дүнд үндэслэн байгууллага бүрийн цахим ил тод байдлын өнөөгийн нөхцөлийг индексжүүлэн тодорхойлсон.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Цахим ил тод байдлын индекс нь цахим мэдээллийг нийтлэхийн давуу ба сул талыг илрүүлэх зорилгоор улс орны болон төрийн байгууллагын цахим ил тод байдлыг үнэлж, тоон үзүүлэлтээр харьцуулан гаргаж буй үзүүлэлт юм. Уг харьцуулсан үр дүнд үндэслэн

байгууллагууд мэдээллийн ил тод байдлынхаа талаар гүнзгий ойлголттой болох зорилгоор индексийг ашиглах нь зүйтэй юм.

Түүнчлэн уг индекс төрийн байгууллага, тэдгээрийн нэгжүүдийн цахим мэдээлэл түгээхтэй холбоотой асуудалд түлхэц үзүүлэх, ил тод ба нээлттэй байх соёлыг хөгжүүлэхэд цахим мэдээллийн ил тод байдал хэрхэн чухал үүрэг гүйцэтгэдгийг мэдээлэх үүрэгтэй юм. Индексийг төрийн удирдлага, цахим засаглал, ил тод байдал, МХХТ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хэн боловч ашиглах боломжтой.

Уг индекс нь ил тод байдлыг гурван үндсэн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд авч үзсэн. Үүнд:

- Эрх зүйн орчин
- Байгууллагын чадамж
- Цахим нээлттэй байдал

Бүрэлдэхүүн хэсэг бүр нь цахим ил тод байдлыг бий болгоход шаардагдах хүчин зүйлс ба тэдгээр дотор багтах хэдэн дэд бүлэг, индикаторуудаас бүрддэг.

## ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКС



**Эрх зүйн орчны** бүрэлдэхүүн хэсэг нь тухайн улс орны мэдээллийн ил тод байдлын эрх зүй, бодлогын орчныг үнэлнэ. Тодруулбал, тухайн улс оронд төрийн байгууллагыг мэдээллээ ил тод, нээлттэй болгох нөхцөлийг хэрхэн хангаж байгаа талаар дэлгэрэнгүй авч үздэг. Зарим тохиолдолд бодлого, засаглалын орчин ил тод байдлыг хангахад саад учруулж байдаг. Түүнчлэн энэ хэсэгт ил тод байдлыг эрэлтийн талаас нь буюу тухайн улсад иргэний нийгэм болон иргэдийн оролцооны хөгжил ямар түвшинд байгааг авч үзнэ. Энэ бүрэлдэхүүн хэсгийг хууль, эрх зүйн баримт бичгээр үнэлнэ.

**Байгууллагын чадамжийн** бүрэлдэхүүн хэсэг нь ил тод байдлыг хэрэгжүүлэхэд байгууллагын чадавх бүрдсэн эсэхийг үнэлнэ. Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь тухайн байгууллагад (i) мэдээллийг ил тод болгох үйл ажиллагааны процедур бүрдсэн эсэх, (ii) мэдээллийг ил тод болгоход шаардагдах нөөц хүрэлцээтэй эсэх, (iii) нээлттэй мэдээллийн санг үүсгэх болон тогтвортой авч явах чадвар байгаа эсэх, (iv) мэдээллийг ил тод болгоход технологийн хэрэгслийг ашиглах чадвар байгаа эсэх зэргийг үнэлнэ. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн үр дүнг байгууллагуудын цахим хуудас хариуцсан албан хаагчдаас мэдээлэл авч үнэлнэ.

**Цахим нээлттэй байдал** бүрэлдэхүүн хэсэг нь цахим хэрэгслээр нээлттэй болгож буй мэдээллийн хэмжээ, цар хүрээг үнэлнэ. Ингэхдээ төрийн байгууллагын цахим хуудсаараа нийтэлж буй мэдээллийн агуулга нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм журамтай хэр нийцэж байгаад төвлөрнө. Уг бүрэлдэхүүн хэсэг нь байгууллага тус бүрийн цахим хуудсанд бидний гаргасан шалгуурын дагуу шаардагдах мэдээлэл байгаа эсэхийг үнэлнэ.

## ТӨСЛИЙН ҮР ДҮН

Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй, шийдвэр гаргах түвшний 72 төрийн байгууллагын хувьд индексийн үр дүнг нэгтгэн тооцлоо. Нийт 12 яам, 17 хэрэгжүүлэгч агентлаг, 9 тохируулагч агентлаг, 19 аймгийн засаг даргын тамгын газар, 7 дүүргийн засаг даргын тамгын газар, 9 парламентын харьяа байгууллагууд хамрагдсан. Цахим ил тод байдлын индексийн нэгдсэн оноо **улсын хэмжээнд 0.612** гарсан нь төрийн байгууллагуудын цахим ил тод байдал нийтээрээ сул түвшинд байгааг харуулж байна.

№	Байгууллагын төрөл	Индексийн нэгдсэн оноо	Эрх зүйн орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
1	Дүүргүүдийн ЗДТГ	0.630	0.657	0.681	0.551
2	Монгол улсын яамд	0.627		0.692	0.532
3	Парламентын харьяа байгууллагууд	0.626		0.745	0.474
4	Аймгуудын ЗДТГ	0.618		0.661	0.529
5	Хэрэгжүүлэгч агентлагууд	0.599		0.622	0.521
6	Тохируулагч агентлагууд	0.579		0.582	0.496
<b>Ерөнхий дундаж</b>		<b>0.612</b>	<b>0.657</b>	<b>0.661</b>	<b>0.518</b>

Харин тохируулагч агентлагуудын ил тод байдлын индекс хамгийн бага буюу 0.598 байна. Эдгээрийн байгууллагын хувьд байгууллагын чадамж болон цахим нээлттэй байдал гэсэн 2 бүрэлдэхүүн хамгийн багаар үнэлэгджээ. Тухайлбал, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын цахим ил тод байдлын индекс хамгийн бага буюу 0.426 оноогоор үнэлэгдсэн байна.

Бүрэлдэхүүн хэсгүүдээр авч үзвэл парламентын харьяа байгууллагуудын байгууллагын чадамж хамгийн өндрөөр үнэлэгдсэн бол дүүргүүдийн ЗДТГ-ын цахим нээлттэй байдал хамгийн өндөр оноо авчээ.

Судалгаанд хамрагдсан 72 байгууллагыг цахим ил тод байдлын индексээр нь эрэмбэлэн жагсаахад Дундговь аймгийн ЗДТГ, Өвөрхангай аймгийн ЗДТГ, ХХААХҮЯ эхний 3 байрт тус тус жагсаж байна.

## ДҮГНЭЛТ

### Байгууллагын чадамж

Байгууллагын чадамж бүрэлдэхүүн хэсгийг үнэлэхдээ тухайн байгууллагын мэдээллийн ил тод байдал буюу цахим хуудас хариуцсан албан хаагчдаас мэдээлэл авсан бөгөөд мэдээлэл цуглуулсан байгууллага бүрд цахим хуудас хариуцсан албан хаагч байсан нь өөрөө эерэг үр дүн байв. Гэсэн хэдий ч байгууллагын нөөцийн хүртээмж болон манлайлал зэрэг

индикаторууд харьцангуй тааруу гарсан нь тухайн хариуцсан албан хаагчийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах, цаашид энэ чиглэлдээ хөгжих, сурч боловсроход сөргөөр нөлөөлөхөөр байна. Энэ нь тухайн ажилтны дотоод болон гадаад сургалт авах үзүүлэлт харьцангуй бага байгаагаар баталгаажиж байна.

### Цахим нээлттэй байдал

Цахим нээлттэй байдлын бүрэлдэхүүн хэсгийн хувьд үнэлгээнд хамрагдсан байгууллага бүр идэвхтэй ажиллаж буй цахим хуудастай байсан. Эдгээр цахим хуудас нь ямар ч хөтөөс (internet explorer, firefox, chrome) хайхад шууд илэрч байв. Үүнээс гадна Монгол Улсын Засгийн газрын цахим хуудсанд (www.zasag.mn) бүх төрийн байгууллагын цахим хуудасны мэдээлэл багтсан, тухайн холбоосоор шууд холбогдох боломжтой зэрэг нь хэрэглэгчдэд төрийн байгууллагын цахим хуудсыг олоход хялбар байдлыг бий болгож байна.

Ихэнх цахим хуудаснууд мэдээллийн төрөл, ангиллаар тусдаа цэсүүдтэй, хаанаас ямар мэдээллийг авах боломжтой талаар ойлгомжтой бүтэцтэй байна. Гэвч тухайн цэсэд оруулсан мэдээллийн агуулга дутуу, хоосон буюу огт мэдээлэл оруулаагүй эсвэл тухайн мэдээллийн шинэчилсэн байдал тодорхойгүй бөгөөд удаан хугацаанд шинэчлээгүй зэрэг нийтлэг дутагдал байв.



# МОНГОЛЫН НИЙГМИЙН САЙН САЙХАН БАЙДЛЫН СУДАЛГАА



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

IRIM судалгааны хүрээлэн, Олон улсын Нийгмийн сайн сайхан байдлын судалгааны консорциум

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Нийгмийг бүхэлд нь тайлбарлах судалгаа Монгол улсад дутмаг байгаатай холбоотойгоор нийгмийн суурь судалгааг олон түүврийн хүрээнд тогтмол хугацаанд үргэлжлүүлэн явуулж олон улс орон, цаг хугацааны туршид харьцуулалт хийх боломжийг бий болгох зорилгын хүрээнд уг төлийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ жилийн хувьд Монгол, Тайланд, Индонез, Филиппин, Вьетнам, Япон, Өмнөд Солонгос, Тайвань зэрэг Азийн найман орны аз жаргалд хөтлөгч хүчин зүйлсийн онцлог болон олон талт байдлыг судлах үндсэн зорилгын хүрээнд чанарын судалгаа зохион байгуулсан.




2019

4-р сар

2022

3-р сар

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



*Улаанбаатар хотод болон хөдөөгийн 12 аймаг (Архангай, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Завхан, Орхон, Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл, Хэнтий)-ийг хамран судалгааны мэдээлэл цуглуулаад байна.*

### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Манай байгууллага нь “ОУ-ын Нийгмийн сайн сайхан байдлын судалгааны консорциум”-д анх 2016 онд гишүүнээр элссэн бөгөөд жилд 1-2 удаа энэ чиглэлийн ОУ-ын хэмжээний томоохон хурал цуглаанд өгүүлэл, илтгэл хэлэлцүүлэх, судалгаа, эрдэм шинжилгээний ажил зохион байгуулах зэргээр хамтран ажиллаж байна. Энэ жилийн хувьд Монгол, Тайланд, Индонез, Филиппин, Вьетнам, Япон, Өмнөд Солонгос, Тайвань зэрэг Азийн найман гишүүн орны судлаачид хамтран Азийн орнуудад хувь хүний аз жаргалыг дэмжихэд чиглэсэн нийгмийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ашиглах, ОУ-д харьцуулагдах боломжтой мэдээлэл цуглуулах үүднээс уг төслийг хэрэгжүүлж эхлээд байна.

### ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төслийн хүрээнд Улаанбаатар хот болон хөдөө орон нутгаас нийт 24 оролцогчийг судалгаанд хамруулсан бөгөөд амьдралын

түүх судлах чанарын судалгааны аргыг голчлон ашиглав. Судалгаанд оролцогчдыг 2016 оноос эхлэн санаачлан хэрэгжүүлж буй “Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”-нд оролцогчдоос сонгон хамруулсан бөгөөд нас, хүйс, аз жаргалын түвшин, гэрлэлтийн байдал, хүүхдийн тоо зэргийг сонголтын үндсэн шалгуур болголоо.

Улаанбаатар хотын мэдээлэл цуглуулалтыг 2019 оны 9 сард уг төслийн үндсэн судлаач болох Японы Сэншү Их сургуулийн профессор Масаюүки Канай, Сэйкэй Их сургуулийн профессор Жүн Кобаяаши нартай хамтран зохион байгууллаа. Хөдөө орон нутгийн мэдээлэл цуглуулалтыг 2020 оны 8 сард зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.

### ҮР ДҮН, ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Энэхүү төсөл нь жилийн тайлан гарах явцад хэрэгжиж байсан ба 2020 оны 12 сард үр дүн, дүгнэлт эцэслэгдэх тул энэ хэсэгт одоогоор ямар нэгэн мэдээлэл оруулах боломжгүй байна.

## ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРТ ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ЭРСДЭЛД СУУРИЛСАН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО БИЙ БОЛГОХ ТӨСӨЛ



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ASIAN DEVELOPMENT BANK



### ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам

### САНХҮҮЖҮҮЛЭГЧ

Азийн Хөгжлийн Банк

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн үндсэн зорилго нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын онцлог нийцүүлсэн, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ үнэлгээ, эрсдэлд суурилсан дотоод аудитын (ХШҮДА) тогтолцоог бэхжүүлэхэд шаардагдах аргазүй, аргачлалыг боловсруулах явдал байв. ХШҮДА-ын тогтолцоог дараах хүрээнд авч үзлээ.



# 2019

4-р сар

# 2020

4-р сар

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хот, Хэнтий аймаг

Дүрс 1 ХНХ-ын салбарын ХШҮДА-ын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг



## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

2016 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль батлагдаж, 2019 онд Төрийн албаны тухай хууль шинэчлэгдэхийн сацуу эдгээр хуулийг хэрэгжүүлэх журмууд гарсан билээ. Ингэснээр ХШҮ ба дотоод аудитын хууль, эрх зүйн орчинд нэлээдгүй шинэчлэл хийгдээд байна. Тиймээс уг шинэчлэлд нийцүүлэн ХНХЯ-ны салбарын бодлогын баримт бичиг, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ ба үнэлгээ явуулах, эрсдэлийг цаг алдалгүй тооцож урьдчилан сэргийлэх, дотоод аудитыг удирдлагын тогтолцоонд ашиглах үйл явц, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах хэрэгцээ үүссэний үндсэн дээр уг төсөл хэрэгжлээ.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төслийг дөрвөн үндсэн үе шаттайгаар хэрэгжүүллээ. Үүнд:

Эхлэл үе шат- Хамтрагч болон оролцогч талуудтай төслийн хамрах хүрээ, зорилго,

зорилтын талаар хэлэлцэн тохиролцож, ХНХ-ын салбарын ХШҮДА-ын өнөөгийн нөхцөл байдал, эрх зүйн орчинд баримт бичгийн шинжилгээ хийсний үндсэн дээр төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөг нарийвчлан боловсруулав.

**ХШҮДА-ын тогтолцоог сайжруулах санал боловсруулах үе шат**- ХНХ-ын салбарын онцлогт нийцсэн үр дүнд суурилсан ХШҮ, эрсдэлд суурилсан ДА-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах хэрэгцээ, ажилчдын чадавхын түвшин зэргийг тодорхойлж, олон улсын туршлагыг харьцуулан судаллаа.

**Чадавх бэхжүүлэх модуль, гарын авлага боловсруулах үе шат**- Сайжруулах саналуудад үндэслэн салбарын ХШҮДА-ын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд сургагч багш нарын ашиглах сургалтын хөтөлбөр, модуль ба агуулгыг боловсруулж туршсан.

**Төгсгөлийн үе шат**- Төслийн хүрээнд нийт есөн төрлийн бүтээгдэхүүнүүдийг боловсруулж,

захиалагчид хүргүүлсэн. Үүнээс гадна төслийн үр дүн, сайн туршлагыг бусад яам, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлагууд, ОУБ-ууд болон донорууд зэрэг холбогдох байгууллагуудад тархаах, хэлэлцүүлэх ажлыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

## ҮР ДҮН

ХШҮДА-ыг зохион байгуулах аргачлал-ХНХ-ын салбарын бодлогын баримт бичиг (БББ)-ийн хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, эрсдэлд суурилсан дотоод аудит хийх, эдгээрийг уялдуулах аргачлалыг боловсруулсан. Энэхүү аргачлал нь төслийн үндсэн бүтээгдэхүүн бөгөөд ХШҮДА-ын ажлыг нэгтгэн төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах зохицуулалт, анхаарах зүйлс, бусад баримт бичиг, зохицуулалттай уялдах уялдааг багтааснаараа онцлог юм.

Хүснэгт 1. Боловсруулсан шинэ аргачлалын хуучин аргачлалтай харьцуулагдах байдал

Хүрээ	Хуучин аргачлал	Боловсруулсан шинэ аргачлал
<b>Хамрах хүрээ</b>	6 бүлэг, 8 хавсралт, 3 агентлагийг хамруулсан	13 бүлэг, 7 хавсралттай бөгөөд 4 агентлаг ба орон нутгийн хамруулж, тэдгээрийн зохицуулалтыг багтаасан.
<b>Аргазүй</b>	ХШҮ ба ДА тусдаа	ХШҮ ба ДА-ын уялдааг тусгасан, гүйцэтгэл, төлөвлөлт, төсөвлөлт, тайлагналт гэсэн үе шаттай байхаар боловсруулсан.
<b>Аргачлал</b>	Шалгуур үзүүлэлт нийцтэй биш, статистик, мэдээллийн сан тодорхой бус.	“SMART” шалгуур үзүүлэлт, Тогтвортой хөгжлийн зорилго ба Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-тай уялдсан, эрсдэлийг таних аргачлал, жендерийн үзүүлэлт, Бизнесийн Ухаалаг Мэдээллийн Системтэй уялдах статистик, сургалт, зөвлөгөө зэрэг багтсан.
<b>Тайлагналт</b>	ХШҮ-ний тайлан	Төрийн албан хаагчийн тайлагнал, БББ-ийн тайлагнал, нэгжийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын үйл ажиллагааны тайлан, дотоод аудитын тайлан зэрэг ялгаатай байдлаар тусгасан.

## ХШҮДА-ын Шалгуур үзүүлэлтүүд ба хэрэглэгдэхүүнүүд

ХНХЯ-ы үйл ажиллагааг үнэлэхэд ашиглагддаг шалгуур үзүүлэлтүүдийг “SMART” зарчмыг баримтлан сайжруулав. Тодруулбал:

Specific - Тодорхой байх (хоёрдмол утгагүй)

Measurable - Хэмжигдэхүйц (тоон ба чанарын)

- Achievable - Хүрэхүйц (ХШҮ хийх боломжтой байх)

- Relevant- Тохиромжтой байх (гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай үндэслэлтэй)
- Time-bound – Цаг хугацаатай байх.
- БББ-үүдийг шүүхэд ХНХЯ-д хамаарах нийт 206 шалгуур үзүүлэлт байсан бөгөөд эдгээрийг чанаржуулж, цөөлсний үндсэн дээр нийт 135 шалгуур үзүүлэлтийг ашиглахыг санал болголоо.

Хүснэгт 2. Шалгуур үзүүлэлт сайжруулсан тойм

Салбараар	Анх тодорхойлсон	Хэвээр үлдээсэн	Өөрчилсөн	Хассан	Шинээр нэмсэн	Одоогийн нийт
Хөдөлмөр	90	25	4	61	3	32
Нийгмийн халамж	36	27	8	1	0	34
Нийгмийн даатгал	28	26	0	2	0	26
Хүн амын хөгжил	52	28	15	9	0	43
<b>Нийт</b>	<b>206</b>	<b>106</b>	<b>27</b>	<b>73</b>	<b>3</b>	<b>135</b>

### ХШҮДА-ын Мэдээллийн систем

Төслийн хүрээнд ХНХ-ын салбарт ХШҮДА зохион байгуулахад ашиглагдах мэдээллийн системийн туршилтын хувилбарыг захиалагчид боловсруулж өгөв. Уг туршилтын мэдээллийн систем нь “Microsoft Access” программд суурилсан бөгөөд дараах үндсэн хэсгүүдтэй. Үүнд:

1. Мэдээллүүдийг агуулах мэдээллийн сангууд (tables)
2. Эдгээрийг холбож дүгнэх шинжилгээ (query)

3. Шинжилгээний үр дүнг гарах тайлан (report)
4. Мэдээллийн сан, тайлан, шинжилгээг ашиглах хэрэглэгдэхүүн, зааварчилгаа (form)

Уг мэдээллийн системийн гол суурь болсон мэдээллийн сан дараах үндсэн хэсгээс бүрдэнэ. Мөн мэдээллийн санд нэмэлт сангууд үүсгэж, холбох болохуйцаар боловсрууллаа.

Дүрс 3. Мэдээллийн сангууд

### Шалгуур үзүүлэлтүүд (бодлогын ба байгууллагын үйл ажиллагааны)

ХШҮДА-ын төлөвлөгөө

Үнэлгээний жингийн коэффициент

Хөтөлбөрийн Санхүү

Албан тушаалын тодорхойлолт

Бодлогын баримт бичгүүд

Явц (тухайн шалгуур үзүүлэлтийн)

ХНХЯ-ны ХШҮДА-ын мэдээллийн системийн үндсэн мэдээллүүдийг бүрдүүлж, холбосны дараа мэдээллийн санг ашиглан ХШҮДА хийх, цаашлаад салбарын бодлого төлөвлөлт, хэрэгжүүлэлтэд шаардлагатай мэдээллийг боловсруулан гаргахад мэдээллийн системийг ашиглах боломжтой юм. Түүнчлэн уг систем мэдээллийг олон янз, хэлбэрээр боловсруулан гаргах боломжийг бүрдүүлсэн.

### ХШҮДА-ыг зохион байгуулах чадавх бэхжүүлэх гарын авлага, сургалтын модулиуд

Салбарын мэргэжилтэн, удирдлагад салбарын ХШҮДА-ын тогтолцооны бүрэлдэхүүн бүрээр нэгдсэн ойлголт, мэдлэг олгох зорилгоор “ХНХ-ын салбарын ХШҮ ба ДА-ын чадавх бэхжүүлэх сургалтын багц модуль”-ийг боловсруулахын зэрэгцээ сургагч багш нарт зориулсан сургалтын гарын авлага боловсруулаа. Сургагч багшийн гарын авлага нь модуль бүрийн тест, дадлага ажлын зааварчилгаа, илтгэлийн материал зэргийг агуулна.

### Хүснэгт 3. Сургалтын модулийн ерөнхий бүтэц

#	Title
Модуль 1	ХШҮ-ний тухай ерөнхий ойлголт, Засгийн газрын ХШҮ-ний эрх зүйн орчин, тогтолцоо
Модуль 2	ХНХЯ-ны хяналт-шинжилгээ, үнэлгээ ба дотоод аудитыг хэрэгжүүлэх үйл явц
Модуль 3	ХНХ-ын салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаанд үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шинэ аргачлал
Модуль 4	Шалгуур үзүүлэлт тодорхойлох арга зүй
Модуль 5	ХШҮДА-ын мэдээллийн систем
Модуль 6	Хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцааны салбарын бодлогын хэрэгжилт, үйл ажиллагаанд ХШҮ хийхэд баримтлах шалгуур үзүүлэлт тодорхойлох
Модуль 7	Нийгмийн халамжийн салбарын бодлогын хэрэгжилт, үйл ажиллагаанд ХШҮ хийхэд баримтлах шалгуур үзүүлэлт тодорхойлох
Модуль 8	Нийгмийн даатгалын салбарын ажилд ХШҮ хийхэд баримтлах шалгуур үзүүлэлт тодорхойлох
Модуль 9	Хүн амын хөгжлийн салбарын бодлогын хэрэгжилт, үйл ажиллагаанд ХШҮ хийхэд баримтлах шалгуур үзүүлэлт тодорхойлох
Модуль 10	Байгууллагын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд


#### Цаашдын чиглэл

Төслийн хүрээнд боловсруулсан ХШҮ ба ДА-ын аргазүй, аргачлал, мэдээллийн сан, чадавх бэхжүүлэх сургалтын модуль, сургагч багшийн гарын авлага зэргийг танилцуулах, салбарын мэргэжилтнүүдээр хэлэлцүүлж, сайжруулах санал авах зорилгоор ХНХЯ болон түүний хэрэгжүүлэгч агентлагийн төлөөллүүдийг оролцуулан 2 өдрийн хэлэлцүүлгийг Улаанбаатар хотод, бүтэн өдрийн сургалтыг Хэнтий аймагт тус тус зохион байгууллаа.

Төслийн хүрээнд боловсруулсан бүтээгдэхүүнүүдийг дан ганц ХНХЯ гэлтгүй өөр яамд, яамны хэрэгжүүлэгч агентлаг, засгийн газрын бусад зохицуулагч, хэрэгжүүлэгч агентлагууд байгууллагынхаа онцлогт нийцүүлэн ашиглах боломжтой юм. Энэ чиглэлээр төслийн үр дүнг тархаах, хэлэлцүүлэх үндэсний хэмжээний уулзалтыг ХНХЯ-тай хамтран зохион байгуулахаар ажиллаж байна.

# ХОТЫН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ (ХЗСТ)-ИЙН ДУНД ШАТНЫ ҮНЭЛГЭЭ

 The Asia Foundation

 Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Азийн Сан болон Швейцарын хөгжлийн агентлаг

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Дунд шатны үнэлгээ нь ХЗСТ-ийн (i) иргэдийн санал хүсэлтийг шийдвэрт тусгахад дэмжлэг үзүүлэх, (ii) иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг сайжруулах, (iii) Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх гэсэн гурван гол зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, төслийн төгсгөлийн шатны суурь мэдээллийг цуглуулах зорилготой юм.





# 2019

11-р сар

# 2020

3-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хотын 9 дүүргийн 42 хороо

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

ХЗСТ нь Швейцарын хөгжлийн агентлагийн (ШХА) Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөрийн II үе шатны хүрээнд хэрэгжиж буй төсөл бөгөөд Азийн сан болон Нийслэлийн засаг даргын тамгын газар (НЗДТГ) хамтран хэрэгжүүлж байна. Уг төсөл иргэдэд тулгамдсан асуудлын талаарх мэдээллийг бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад хүргэх, иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, нийслэлийн нутгийн захиргааны ажилтнуудын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх замаар хотын оршин суугчдын амьжиргааг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулахыг зорин ажиллаж байна.

Төслийн эхний үе шат (2015-2019) дуусаж, хэрэгжилтийн дараагийн үе шатанд (2020-2022) шилжиж буйтай холбоотойгоор энэхүү дунд шатны үнэлгээг IRIM судалгааны хүрээлэнгийн баг олон улсын үнэлгээний зөвлөлтэй хамтран гүйцэтгэлээ. Тус үнэлгээний үр дүн нь төслийн эхний үе шатны эцсийн үнэлгээ болохоос гадна төслийн дараагийн шатны суурь мэдээлэл болж буйгаараа онцлогтой юм.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Үнэлгээний хүрээг боловсруулахдаа ХЗСТ-ийн логик хүрээнд үндэслэн ОУ-ын эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Хөгжлийн тусламжийн хорооны боловсруулсан (OECD-DAC) үнэлгээний дөрвөн шалгуур үзүүлэлтийг ашиглалаа. Ингэхдээ, ХЗСТ нь Монгол Улс болон Нийслэлийн засаглалын талаар баримталж буй бодлого төлөвлөлттэй хэр уялдаж байгаа, Азийн сан болон ШХА-ийн МУ-д хэрэгжүүлж буй стратегийн чиглэлтэй хэр нийцэж буй талаар авч үзлээ. Түүнчлэн төслийн үндсэн үйл ажиллагаа болох иргэдийн хэрэгцээнд тулгуурласан шийдвэр гаргалтыг дэмжих, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах, төрийн албан хаагчдын чадавхыг сайжруулах зэрэг ажлууд нь хэр үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэнийг үнэлэхийн сацуу төслөөс гарсан бүтээгдэхүүн, үйл ажиллагааны цаашдын тогтвортой байдал хэрхэн хангагдсаныг тодорхойллоо.

Дүрс 1. ЭЗХАХБ-ын Хөгжлийн тусламжийн хорооны үнэлгээ ба Үнэлгээний ерөнхий асуулт

ХЗСТ нь МУ болон НЗДТГ-ын хөгжлийн бодлого төлөвлөлттэй, АС болон ШХА-ийн стратегийн зорилтуудтай хэр уялдаатай ажиллаж байна вэ?

Хамааралтай байдал

Шийдвэр гаргагчдыг иргэдийн мэдээллийг ашиглах боломжоор хангах, төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах, төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэхэд төсөл хэр хувь нэмэр оруулсан бэ?

Үр дүнтэй байдал

Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

Төслийн бүрэлдэхүүн, менежмент, бүтэц нь зорилгодоо хүрэхэд үр нөлөөтэй байсан уу?

Үр ашигтай байдал

ХЗСТ иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах, нийслэлийн албан хаагчдын сургалтыг хэр системтэй, тогтвортой хийсэн бэ?

Тогтвортой байдал

## ҮР ДҮН

Төслийн гүйцэтгэлийг үнэлсэн шалгуур үзүүлэлтүүдийн олонх нь зэрэг үр дүнтэй буюу үнэлгээний 36 үзүүлэлтээс 32 нь биелсэн, 4 нь биелэлт хангагдсан боловч цаашид сайжруулах шаардлагатай гэж үнэлэгдлээ. Үнэлгээний ерөнхий шалгуур үзүүлэлт бүрээр гол хүрсэн үр дүнг тоймловол:

**1. Хамааралтай байдал:** ХЗСТ нь МУ-ын хотын засаглалын салбарын бодлого төлөвлөлт, шинэчлэлттэй уялдаатай ажиллахын сацуу НЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээтэй үйл ажиллагаагаа уялдуулан ажиллаж байна. Түүнчлэн ШХА болон Азийн сангийн МУ-д хэрэгжүүлж буй стратегийн зорилтуудтай бүрэн нийцэхийн зэрэгцээ ШХА-ын бусад төслүүдтэй нягт уялдаа холбоотой ажиллаж байна.

**2. Үр дүнтэй байдал:** Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлуудын үр дүнтэй байдлыг зорилт тус бүрийн хүрээнд авч үзвэл:

- **Зорилт 1:** Тус зорилтын хүрээнд ХЗСТ нь Орон нутгийн хөгжлийн санд иргэд байршил, нас, хүйс харгалзахгүйгээр цахимаар саналаа өгөх боломжийг олгосон гар утасны аппликейшн хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүлэх замаар шийдвэр гаргалтад иргэдийн саналыг тусгах боломжийг бүрдүүлж өгсөн. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр өмнөх жилүүдэд хийгдсэн ажлуудын байршлын зураглал болон зорилтот бүлгийн иргэдийн нягтаршлын байр зүйн зураглалыг боловсруулж manaikhoroo.mn сайтад нээлттэй байрлуулсан нь иргэд болон шийдвэр гаргагчдын мэдээллийн эх сурвалжийг нэмэгдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан ажил болжээ.
- **Зорилт 2:** Захиргааны 4 төрлийн үйлчилгээг хорооны түвшинд шилжүүлэх туршилтын

ажлыг гүйцэтгэсэн нь төрийн үйлчилгээний төвлөрөлтэй холбоотой иргэдэд тулгамддаг хүндрэлүүдийг багасгахад, төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах Нийслэлийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд хувь нэмэр оруулсан, үр дүнтэй ажил болсон.

- **Зорилт 3:** Хороо, дүүрэг, нийслэлийн түвшний албан хаагчдын хэрэгцээнд үндэслэсэн сургалтын хүрээг боловсруулж НЗДТГ-ын хүний нөөцийн бодлогод тусгах, тус сургалтын хүрээг хэрэгжүүлэх зорилготой “Сургалтын төв”-ийг НЗДТГ-ын дэргэд байгуулахад дэмжлэг үзүүлсэн нь төрийн албан хаагчдыг чадавхжуулахад төслийн оруулсан бодитой хувь нэмэр болжээ.

**3. Үр ашигтай байдал:** Төсөл нь нийслэлийн захиргааны байгууллагуудтай (хороо, дүүрэг, нийслэл) үр дүнтэй хамтран ажиллаж байна. НЗДТГ-тай нягт хамтран ажилласнаар хороо, дүүрэг зэрэг захиргааны бусад шатлалын байгууллагуудтай хамтарч ажиллах явцад төрийн байгууллагын тогтолцоотой холбоотой хүндрэл, чирэгдэл, хүнд сурталтай холбоотой бэрхшээлтэй бага тулгарчээ.

**4. Тогтвортой байдал:** ХЗСТ нь засаглалын бүхий л түвшинд төрийг үйлчилгээний төвлөрлийг сааруулахад чиглэсэн хандлага төлөвшихөд хувь нэмэр оруулж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах тогтвортой институт бүрдэхэд хувь нэмэр оруулж тэдгээрийн цаашдын тогтвортой байдлыг хангахад анхааран ажиллаж ирсэн байна. Цаашид төслийн хүрсэн ололт амжилтыг тогтвортой үргэлжлүүлэхийн тулд шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах, ялангуяа цахим санал хураалтад оролцох боломжгүй иргэдийн (зорилтот бүлгийн иргэд, ахмад настнууд) оролцоог хэрхэн хангах талаар хувилбаруудыг нэвтрүүлэхэд анхаарах хэрэгтэй.

# ТӨРИЙН БОДЛОГО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Засгийн газрын хэрэг эрхлэх газар

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагаа нь чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй, шуурхай байгаа эсэх талаар иргэдийн санаа бодлыг тандан судалж, дүн шинжилгээ хийх үндсэн зорилготой. Түүнчлэн судалгааны үр дүн, зөвлөмжийг төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, бодлого шийдвэрийг боловсруулах, үнэлэхэд ашигласан.




2019

10-р сарын 07

2020

2-р сарын 17

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хот болон 21 аймаг

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэх, улмаар үнэлгээний үр дүнд үндэслэн төрийн үйлчилгээг сайжруулах, цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаандаа иргэдийн дуу хоолойг тусгах зорилгоор төрөөс тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсээр байна. Тухайлбал,

- 2017 онд Монгол Улсын засгийн газар, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” баталсан.
- 2017 онд Монгол Улсын засгийн газар, “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж” баталсан.
- 2019 онд Үндэсний статистикийн газар, “Төрийн бодлого, үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны түүврийн аргазүй” баталсан зэргийг дурдаж болно.

Эдгээр удирдамж, баримт бичигт үндэслэн Монгол Улсын Засгийн газар (МУЗГ) 2019 оны “Төрийн бодлого, үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа”-г улс орон даяар зохион байгуулаа. Уг судалгааны гол онцлог нь МУЗГ-ын захиалгаар хөндлөнгийн, хараат бус судалгааны байгууллагууд хамтран ажиллаж иргэдээс мэдээлэл цуглуулж, үр дүнг боловсруулсан явдал юм.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгаанд Улаанбаатар хотоос гадна 21 аймгийн 291 сум, 545 багийг хамруулсан бөгөөд нийт судалгаанд оролцогчдын гуравны нэг хувийг хөдөө, орон нутгийн багт амьдардаг иргэд эзэлж байна. Нийт 13,860 иргэн хамруулсан ба Улаанбаатар хотоос 1,680, бусад аймаг бүрээс 580 иргэн судалгаанд оролцлоо.

Судалгаанд оролцуулах иргэдийг сонгохдоо үндсэн хоёр шалгуурыг баримталсан. Үүнд:

1. Насанд хүрсэн (18 ба түүнээс дээш настай) Монгол улсын иргэн байх
2. Сүүлийн нэг жилийн хугацаанд ямар нэгэн төрийн байгууллагаас үйлчилгээ авсан байх


Судалгааны мэдээллийг хоёр төрлийн судалгааны арга ашиглан цуглуулсан. Үүнд:

- Тоон судалгаа (Захиалагчаас санал болгосон асуумж)
- Чанарын судалгаа (IRIM судалгааны

хүрээлэнгийн боловсруулсан фокус бүлгийн ярилцлага (ФБЯ)-ын удирдамж)

## ҮР ДҮН, ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Төрийн үйлчилгээтэй холбоотой иргэдийн сэтгэл ханамжийг 1-5 оноогоор (1-маш муу; 5-маш сайн) үнэлүүлсэн. Иргэдийн төрийн үйлчилгээний талаарх сэтгэл ханамж 3.2 буюу дундаж утгаас (3.0) ялимгүй дээгүүр байв.



Ихэнх аймгууд улсын дундаж (3.2)-тай ойролцоо үнэлгээний үр дүнг харуулсан байна. Улсын хэмжээнд Сэлэнгэ аймаг нь хамгийн өндөр (3.4), Увс аймаг болон Улаанбаатар хот хамгийн муу (2.9) үр дүнг үзүүлсэн байна.

Дээрх дүр зургаас харвал төрийн үйлчилгээний талаарх үнэлгээ баруун 3 аймгийн хувьд бага зэрэг муу байхад төвийн бүсийн аймгуудын үр дүн дунджаас дээгүүр үнэлгээтэй байгаа нь ажиглагдлаа.

Иргэд үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой асуудлыг харьцангуй өндрөөр үнэлж байв.

Салбараар нь авч үзвэл 13 салбарын 11-д нь иргэд сэтгэл ханамжтай байна. Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамж хамгийн өндөр байгаа бол уул уурхайн салбарын үйл ажиллагаанд сэтгэл ханамж хамгийн муу байна. Уул уурхайн нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэл хангалтгүй байгаагаас иргэд бусад үзүүлэлттэй харьцуулахад муугаар үнэлжээ.



Төрөөс сүүлийн нэг жилд гүйцэтгэсэн хамгийн үр дүнтэй ажлаар утааны эсрэг хэрэгжүүлсэн арга хэмжээг нэрлэж байна.

- Утааг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлыг дан ганц Улаанбаатар хотод төдийгүй улсын хэмжээнд үр дүнтэй болсон гэж үзжээ. Томоохон хот суурин газрын иргэд (Дархан, Эрдэнэт, Сэлэнгэ аймгийн төвийн иргэд) шахмал түлшийг өөрийн орон нутагт нэвтрүүлэх шаардлагатай байгаа талаар саналаа илэрхийлж байв.
- Мөн иргэд зам, гүүр засварын ажлууд, барилга байгууламжийн бүтээн байгуулалт, гудамж талбайн тохижилт зэрэг дэд бүтцийн чиглэлээр гүйцэтгэсэн ажлуудын үр дүнд сайшаалтай хандаж байв.

Судалгаанд оролцсон иргэдийн үнэлгээнд тэдний нас, хүйс төдийлөн хамааралгүй байсан бол хотод эсвэл хөдөөд амьдардаг байдлаасаа хамаарч ихэнх үзүүлэлт ялгаатай үнэлэгдсэн.

- Уул уурхай болон ажил эрхлэлт, нийгмийн даатгалд чиглэсэн төрийн үйлчилгээнээс бусад бүх салбарыг Улаанбаатар хотын иргэд хөдөө, орон нутгийн иргэдээс багаар оноогоор үнэлсэн байв.
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг Улаанбаатар хотын иргэд хамгийн тааруу дундажтай үнэлэв. Тэр дундаа үйлчилгээний хүртээмж буюу ачаалалтай байдлыг төв суурин газруудад орон нутагтай харьцуулахад муугаар үнэлжээ.

# МОНГОЛЧУУДЫН АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ БОЛОН СОЁЛЫН СУДАЛГАА I-III



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Японы Кобе их сургууль

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Японы Кобе Их сургуулийн судалгааны багийн санаачлан хэрэгжүүлж буй “Монголчуудын амьдралын хэв маяг болон соёлын судалгаа”-ны тоон мэдээллийг цуглуулах зорилготой.

ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭН/ХЭРЭГЖИХ ХУГАЦАА



2018

3-6-р сар

Туршилт судалгааны мэдээлэл цуглуулалт

2019

1-2-р сар


Суурь судалгааны мэдээлэл цуглуулалт

2020

7-9-р сар

Харьцуулсан судалгааны мэдээлэл цуглуулалт

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хотын Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэг,  
Өвөрхангай аймгийн Хужирт сум

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Японы Кобе их сургуулийн судалгааны баг “Монголчуудын амьдралын хэв маяг болон соёл” сэдэвт судалгааны ажлынхаа хүрээнд судалгааны тоон мэдээлэл цуглуулах үйл ажиллагаандаа мэргэжлийн дэмжлэг авах үүднээс IRIM судалгааны хүрээлэнд анх 2018 онд хандсанаар уг төсөл 3 дахь удаагаа хэрэгжиж байна.

Тоон мэдээлэл цуглуулалтын ажил 2018 онд судалгааны үндсэн аргазүй, хэрэглэгдэхүүн, мэдээлэл цуглуулалтын арга зэргийг турших, 2019 онд төслийн суурь судалгааны мэдээллийг цуглуулах зорилготойгоор хэрэгжиж байв. Үүнээс гадна 2019 оны суурь судалгааны мэдээлэл цуглуулалт хийгдсэний дараа судалгаанд хамрагдсан өрх бүрийн хаягийг Нийслэлийн газрын зураг болон холбогдох бүртгэлүүдтэй тулгаж, бүртгэл санг үүсгэж байв.

Харин энэ удаад 2019 оны суурь судалгааны мэдээлэлд харьцуулалт хийж, судалгаанд оролцсон иргэдийн амьдралын хэв маяг, соёлд гарсан өөрчлөлтийг судлах зорилготой давтан судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг 2020 оны 7 сард эхлэх гэж байна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

2019 онд суурь судалгааны мэдээллийг цуглуулахдаа тоон судалгааны асуулга болон оролцоонд суурилсан тоглоомын аргыг ашиглалаа. Захиалагчаас судалгааны хэрэглэгдэхүүнүүдийг урьдчилан илгээдэг бөгөөд төслийн багаас хэрэглэгдэхүүнүүдийг орчуулах, турших, сайжруулах ажлуудыг хариуцан гүйцэтгэдэг. 2018 болон 2019 оны судалгаанд харгалзан 302 ба 668 өрхийн тэргүүнийг хамруулсан бол 2020 онд 868



өрхөөс мэдээлэл цуглуулахаар ажиллаж байна. Судалгаагаар өрхийн гишүүдийн мэдээлэл, амьдралын орчин нөхцөл буюу дэд бүтэц,

итгэлцэл, улс төрийн оролцоо, нийгмийн харилцааны талаар мэдээллийг цуглуулж байна.

Хүснэгт 1. Түүврийн хэмжээ, жил, зорилтот талбараар


Year	Хот/аймаг	Дүүрэг/сум	Хороо/баг		Нийт	
2018 оны туршилт судалгаа	Улаанбаатар хот	Сүхбаатар дүүрэг	11-р хороо	Орон сууцны оршин суугчид	302	
			12-р хороо	Гэр хорооллын оршин суугчид		
		Сонгинохайрхан дүүрэг	19-р хороо	Орон сууцны оршин суугчид		
			7-р хороо	Гэр хорооллын оршин суугчид		
	Өвөрхангай аймаг	Хужирт сум	5-р баг	Сумын төвийн оршин суугчид		
2-р баг			Сумын төвөөс зайдуу оршин суудаг иргэд			
2019 оны суурь судалгаа	Улаанбаатар хот	Сүхбаатар дүүрэг	18-р хороо	Гэр хорооллын дэд бүтцийн төвийн үйлчилгээ нэвтрэх бүсийн оршин суугчид	668	
		Чингэлтэй дүүрэг	7-р хороо			
2020 оны харьцуулсан судалгаа	Улаанбаатар хот	Сүхбаатар дүүрэг	18-р хороо	Гэр хорооллын Дэд бүтцийн төвийн үйлчилгээнд хамрагдсан/ хамрагдаагүй оршин суугчид	868	
			20-р хороо	Дэд бүтцийн төлөвлөлтгүй бүсэд оршин суугчид		
		Чингэлтэй дүүрэг	7-р хороо	Гэр хорооллын дэд бүтцийн төвийн үйлчилгээнд хамрагдсан/хамрагдаагүй оршин суугчид		

## ҮР ДҮН, ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Энэ ажлын хувьд IRIM судалгааны хүрээлэн иргэдээс тоон мэдээлэл цуглуулж, цугларсан мэдээлэлд чанарын хяналт хийх, нэгдсэн мэдээллийн санг үүсгэх, мэдээлэл цуглуулалтын

техникийн тайлан боловсруулах үүрэгтэй бөгөөд судалгааны үр дүнг боловсруулж, олон нийтэд танилцуулах эрхгүй билээ.

## ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА



### ЗАХИАЛАГЧИЙН НЭР

ХНХЯ-ны харьяа Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа мэдээллийн үндэсний төв

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Судалгааны зорилго нь төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, тэдний ажлын байранд зуучлагдаж буй хэлбэр, хугацаа, ур чадварын нийцэл, түүнчлэн ажлын байранд тулгарч буй асуудал болон ажилгүй байгаа шалтгаан зэргийг илрүүлэн хөдөлмөрийн зах зээл дэх өөрчлөлтийг тодорхойлдог. Энэхүү мэдээллээрээ салбарын бодлого боловсруулагчид, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын шийдвэр гаргагчид, судлаачдыг тоон мэдээллээр хангагдгаараа ихээхэн ач холбогдолтойд тооцогддог.

Судалгааны хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллалаа. Үүнд:

- Судалгааны аргагүй, хэрэглэгдэхүүн, түүврийн аргачлалыг г туршиж, судалгааны мэдээллийг түргэн шуурхай, үр дүнтэй цуглуулах нэгдсэн аргачлалыг боловсруулав.
- Улс орон даяар тархан суурьшсан 5000 орчим төгсөгчдийг судалгаанд хамруулах ажлыг гүйцэтгэхэд хүрэлцэхүйц хэмжээний судлаачдын багийг бүрдүүлж, сургаж бэлтгэлээ.
- Үндэсний хэмжээнд мэдээлэл цуглуулах ажлын төлөвлөгөө боловсруулж, бүрэн мэдээлэл бүхий чанартай судалгааг таблет аппликэйшн ашиглан тогтсон хугацаанд цуглуулав.
- Цугларсан мэдээллийн үнэн зөв найдвартай байдлыг хянан, засварлаж, мэдээллийн найдвартай байдлыг хангалаа.
- Мэдээллийг шивж, цэвэрлэн, алдаагүй нэгдсэн мэдээллийн сан үүсгэх ажлыг богино хугацаанд зохион байгуулав.
- Судалгааны бусад олдворууд, холбоо барих хаяг, координат, зочлолтын баримтуудыг нэгтгэн эмхэллээ.
- Мэдээлэл цуглуулалт болон мэдээлэл оруулалтын үйл явцыг багтаасан эхлэлийн, явцын болон техникийн, эцсийн тайлангуудыг боловсруулан захиалагчид хүлээлгэн өглөө.




# 2019

7-р сарын 05

# 2019

12-р сарын 12

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хот, 21 аймаг

### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

“Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа” нь мөшгөх судалгааны аргачлалын дагуу үндэсний хэмжээнд зохион байгуулагддаг судалгаа юм. Энэ удаагийн судалгаанд их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг 2015-2016 оны хичээлийн жилд төгссөн төгсөгчдийг гурав дахь жилдээ мөшгөн судаллаа.

Хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийг ажил мэргэжлийн түвшинд судлах явдал нь бодлого боловсруулахад ихээхэн ач холбогдолтой. Төгсөгчдийн ХЗЗ-ийн өөрчлөлтийг хянахдаа

- (i) ажилгүйдлийн шалтгааныг тодорхойлох,
- (ii) хөдөлмөрийн зах зээлд бэлэн буй ажлын байрны шаардлагад сургалтын байгууллагаас нийлүүлэгдэж байгаа мэргэжилтний ур чадвар нийцэж байгаа эсэх,
- (iii) төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, тэдний ажил мэргэжлийн хэтийн төлөвлөгөө

зэрэг асуудлыг тоон болон чанарын үзүүлэлтээр

судалж, бодлого боловсруулагчид болон хэрэглэгчдэд хүргэдэг.эд

### ТӨСЛИЙН ДИЗАЙН

Тус судалгаа нь судалгаанд түүвэрлэгдэн сонгогдсон оролцогчдыг дөрвөн жил дараалан мөшгөн судалж, панел мэдээллийн сан үүсгэдгээрээ ихээхэн онцлогтой юм. Судалгааны мэдээллийг асуумж судалгааны аргаар цуглуулдаг бөгөөд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, мэргэшил дээшлүүлж буй нөхцөл байдал, ажлын байрны сэтгэл ханамж, ур чадварын байдлыг нь судлан тодорхойлдог.

### ҮР ДҮНГҮҮД ЦААШДЫН ЧИГЛЭЛ

IRIM судалгааны хүрээлэн уг судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг хариуцан гүйцэтгэсэн бөгөөд судалгааны үр дүнг боловсруулан, тайлагнах шатад оролцоогүй болно.

## 'ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ НЬ' ТӨСЛИЙН СУДАЛГАА



БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН ЯАМ



ASIAN DEVELOPMENT BANK



### ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Азийн Хөгжлийн Банк (АХБ), Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам (БСШУСЯ)

### САНХҮҮЖҮҮЛЭГЧ

АХБ-ны 9216-MON "Эдийн засгийн хүндрэлтэй үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах нь" техникийн туслалцааны хүрээнд Японы Ядуурлыг Бууруулах Сангийн санхүүжилтээр гүйцэтгэв.

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО

АХБ-ны техникийн туслалцааны төслийн зорилтот орон нутагт амьдарч буй 2-17 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй буюу хөгжлийн бэрхшээлтэй байх өндөр эрсдэлтэй хүүхдүүдийг илрүүлэн, тэдгээр хүүхдийн боловсролын тусгай хэрэгцээг хангахад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодруулж, сургалтын үйл ажиллагааг сайжруулах санал зөвлөмжийг боловсруулах зорилготой.



# 2019

2-р сар


# 2019

10-р сар

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

1. Дархан-Уул аймгийн Дархан сум
2. Ховд аймгийн Жаргалант сум
3. Дундговь аймгийн Мандалговь сум
4. Хөвсгөл аймгийн Цагааннуур сум
5. Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нийт 9 байршил (хороо)

Нэмэлтээр соёлын цөөнх, алслагдмал орон нутгийн иргэд, малчин өрх зэрэг судалгаанд дуу хоолой нь бага тусгах магадлалтай бүлгүүдийг тэгш хамруулах зорилгоор Баян-Өлгий, Баянхонгор, Орхон, Сэлэнгэ, Дорноговь, Дорнод аймгийн 8 сумын иргэдтэй гүнзгийрүүлсэн ярилцлагын аргаар мэдээлэл цуглууллаа.



## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

2016 онд батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах, сургуульд үр дүнтэй хамруулахын тулд эцэг эхчүүд хүүхдүүдээ сургуульд хамруулах үүрэг хүлээх, сургуулийн нийгмийн ажилтнууд эцэг эхийг шаардлагатай мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлэх, сургуулийн зүгээс хүүхдийн тусгай хэрэгцээнд нийцүүлэн шаардлагатай тохируулга, зохицуулалтыг хийх үүргийг тус тус хүлээлгэсэн юм<sup>1</sup>. Гэсэн хэдий ч олон судалгааны үр дүн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролын чанартай үйлчилгээний гадна үлдсээр байгааг харуулсаар байна. Боловсролын доогуур түвшин нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуусын эмзэг байдлын гол шалтгаан болж байна. Өнөөдрийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 5 хүн тутмын 1 нь ямар нэгэн боловсрол эзэмшээгүй байгаа нь бусад хүн амын бүлэгтэй харьцуулахад 4 хувиар доогуур үзүүлэлт юм.<sup>2</sup>

2018 онд батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх оролцоо, хөгжлийн дэмжих үндэсний хөтөлбөр”-т хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн

боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх хууль эрх зүй, бодлогын хүрээг тодорхойлох зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын хэрэгцээ шаардлагыг судлах судалгааны ажлыг гүйцэтгэхээр тусгасан. Тус зорилтын дагуу АХБ-ны “Эдийн засгийн хүндрэлтэй үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах нь” техникийн туслалцааны төслийн хүрээнд тус судалгааны ажлыг БСШУСЯ, АХБ-ны захиалгаар IRIM судалгааны хүрээлэн гүйцэтгэв.

## СУДАЛГААНЫ ДИЗАЙН

Тус судалгаанд олон улсад хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чиглэлээр ашиглаж буй аргачлал болон тэгш хамруулах боловсролыг дэмжих чиглэлээр ашиглагдаж буй хүний эрхийг дэмжсэн жишиг аргачлалуудыг үндэсний контекстэд нийцүүлэн өөрчилөн ашиглалаа. Зорилтот өрхүүдийн нийгэм эдийн засаг, соёлын үзүүлэлтүүдийг тооцохдоо улсын хэмжээний томоохон түүвэр судалгаа болох ҮСХ-ны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018-ын үр дүнтэй харьцуулагдахуйц байдлаар ижил төстэй аргазүйг баримталж ажиллав. Судалгааг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлсэн бөгөөд үе шат бүрд ялгаатай аргазүйг ашиглалаа.

<sup>1</sup> 2016 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д заасны дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ;  
<sup>2</sup> Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмд нэгтгэх нь, Ажиглалт болон Зөвлөмжүүд, Манила АХБ, 2019а

Хүснэгт 1. Судалгааны үе шат, ашигласан аргагүйн тойм

№	Судалгааны үе шат	Хийгдсэн үйл ажиллагаа	Ашигласан аргачлал
1	Бэлтгэл шат	<ul style="list-style-type: none"> <li>Тэгш хамруулан сургах боловсролын орчныг хэмжих чиглэлээр хийгдсэн судалгааны аргагүйд шинжилгээ хийв.</li> <li>ХБХ-ийн сургалтын нөхцөл байдлыг баримт бичгийн шинжилгээнд үндэслэн судлав.</li> <li>Судалгааны аргагүй, хэрэглэгдэхүүнийг боловсруулав.</li> </ul>	Баримт бичгийн шинжилгээ
2	1-р шатны тоон мэдээлэл цуглуулалт	Төслийн зорилтот орон нутгийн сонгогдсон сум, хорооны 2-17 насны хүүхдүүдийн дунд үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдийг илрүүлэх үнэлгээг зохион байгууллаа.	ОУ-ын Вашингтон бүлгийн Хүүхдийн үйл ажиллагаа модуль 2-5, 6-17 насны хувилбар
3	2-р шатны тоон ба чанарын мэдээлэл цуглуулалт	Илрүүлэх үнэлгээнээс нэг болон түүнээс дээш үйлдлийн чадварын хувьд хүндрэлтэй хүүхдүүдийн сургууль, СӨБ-д хамрагдалт, боловсролын хэрэгцээ шаардлагыг тодруулах тоон болон чанарын мэдээллийг цуглууллаа.	Мэл Аинсков, Тони Бүүт нарын "Тэгш хамруулах боловсролын индекс"-д үнлэсэн боловсруулсан 7 төрлийн хэрэглэгдэхүүн
4	Датаг цэвэрлэх, нэгтгэх, шинжлэх үе шат	Нийт хоёр шатнаас цугларсан мэдээлэлд 3 үе шаттайгаар чанарын хяналтыг хийж, мэдээллийг нэгтгэх, цэвэрлэх, боловсруулах ажлыг хэрэгжүүллээ.	Дескриптив болон харьцуулсан шинжилгээ
5	Тайлан боловсруулах үе шат	Үр дүнд шинжилгээ хийж тайлан боловсруулан, үр дүнг оролцогч талуудад танилцуулав.	

Уг судалгааны түүврийн дизайныг боловсруулах явцад мэдээллийн хязгаарлагдмал байдал, судалгааны төсөв зэрэг хүчин зүйлээс шалтгаалан зорилтот түүврийн аргыг ашиглалаа. Харин сонгогдсон нэгжийн түвшинд зорилтот эх олонлогийг бүрдүүлж, илрүүлэх үнэлгээг хийхдээ нэлэнхий ажиглалтын аргаар судалгааг хийж гүйцэтгэв. Иймд тус судалгааны үр дүн ямар нэгэн төлөөллийг илтгэхгүй зөвхөн сонгогдсон нэгжийн түвшний үр дүнг илэрхийлнэ.

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Нэгдүгээр шатанд төслийн зорилтот орон нутагт байрлах 5,296 өрхийн 2-17 насны 9,555 хүүхдэд илрүүлэх үнэлгээг хийхэд судалгаанд оролцсон нийт хүүхдийн 9.1 хувь нь ямар нэгэн үйлдлийн чадварын хүндрэлтэй байна. Хүүхдийн насны бүлгээр нийтлэг илэрсэн үйлдлийн чадварын хүндрэлийг авч үзвэл:

- 2-5 насны хүүхдүүдийн хувьд илүү зан авираа удирдах, бусадтай харилцах, суралцах, тоглох зэрэг үйлдлийн чадваруудын хувьд хүндрэлтэй байна.
- 6-17 насны хүүхдүүдийн хувьд сэтгэл түгших, сэтгэл гутрах шинжүүд хамгийн түгээмэл илэрч байна.

Судалгааны үр дүнгээр хүүхдийн нас нэмэгдэхийн хэрээр харах, сэтгэл түгших, гутрах шинжүүд нэмэгддэг болох нь тогтоогдсон бөгөөд эдгээр үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдэд чиглэсэн боловсролын дэмжлэг, оновчтой бодлого, үйлчилгээ зайлшгүй шаардлагатай байна.

Үйлдлийн чадварын хүндрэлтэй болох нь илэрсэн хүүхдүүдийн сурч боловсроход тулгарч буй хүндрэл бэрхшээл, боловсролын хэрэгцээ шаардлагыг судлах зорилгоор "Тэгш хамруулах боловсролын индекс"-ийг тооцлоо. Ингэхдээ тэгш хамруулсан боловсролын бодлогын орчин, соёлын орчин, материаллаг орчин, практик туршлага гэсэн үндсэн 4 индикаторын хүрээнд тооцсон бөгөөд өрхийн нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдтэй харьцуулан судаллаа. Тухайн сонгогдсон орон нутгийн хэмжээнд тэгш хамруулах боловсролын бүх үзүүлэлт хангалтгүй, дөнгөж бий болох шатандаа явж байгаа гэсэн үр дүн гарлаа. Ялангуяа үйлдлийн чадварын хүндрэлтэй хүүхдүүд цэцэрлэг, сургуульд элсэж байгаа ч сургуулийн дотоод орчин, сургалтын арга барил, аргагүйд тэдгээр хүүхдийн онцлог тусгай хэрэгцээг харгалзах, нэмэлт тохируулга хийх байдал хангалтгүй байна.

# "ЗАЛУУСЫН ТОГТВОРТОЙ АЖИЛ ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР"-ИЙН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Зориг сан

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Зориг сангаас санаачлан хэрэгжүүлсэн "Залуусын тогтвортой ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн эхлэл, дунд, төгсгөл үе шатуудад хяналт-шинжилгээ хийн хөтөлбөр хэрэгжсэний дараа үнэлгээ хийж, хөтөлбөр хэрэгжүүлэгчдэд уг хөтөлбөрийг цаашид сайжруулах санал, зөвлөмж өгөх зорилготой. Энэ хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүллээ. Үүнд:

- Хөтөлбөрт оролцогчдын мэдлэг, ур чадварт гарсан өөрчлөлтийг үнэлэх
- Хөтөлбөрт тусгагдсан сургалтуудаас гадна оролцогчдын нэмэлт сургалтын хэрэгцээг тодорхойлох
- Оролцогчдын хөтөлбөрөөс хүлээж буй хүлээлт нь тэдний хүлээлттэй нийцсэн эсэхийг тодорхойлох
- Хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн сургалтын үр өгөөжийг үнэлэх.



# 2019

1-р сар

# 2019

10-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хот

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ


Нийгэмд залуучуудын эзлэх байр суурь, үүрэг оролцоо их байдагтай холбоотойгоор залуучууд аливаа улс үндэстний тулгуурт тооцогддог. Монгол улсын хувьд нийт хүн амын 63.7 хувийг залуучууд эзэлдэг бөгөөд тэдний 34.6% нь 15-34 насныхан бөгөөд нийт хөдөлмөрийн насны хүн амын 50 гаруй хувийг бүрдүүлж байна. Гэсэн хэдий ч хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн чиг хандлагаас харахад залуучуудын ажилгүйдэл улсын дундаж ажилгүйдлийн төвшнөөс даруй 50 хувиар илүү байна. 2017 оны байдлаар нийт 29,164 залуус их дээд сургууль, коллеж, мэргэжил олгох сургалтын байгууллагыг төгссөн байна. Нийт төгсөгчдийн 70% нь л хөдөлмөр эрхэлж байгаа бол үлдсэн 12% нь ажилгүй, 18% нь эдийн засгийн идэвхгүй байдалд байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс 2017 онд хэрэгжүүлсэн Залуучуудын ажилгүйдэл, эдийн засгийн идэвхгүй байдлын судалгааны үр дүнгээс харахад шинэ төгсөгчдийн 26.2% нь ажил эрхэлсэн туршлага хомс, 20% нь ар гэрийн асуудал, 19.5% нь ажлын байранд шаардагддаг мэдлэг, ур чадвар

хомс байгаа нь хөдөлмөр эрхлэхэд хамгийн том саад бэрхшээл болдог гэж дүгнэсэн байна. Харин ажил олгогчдоос шинээр ажилтан авахад тулгардаг гол бэрхшээлийг тодруулахад 22.2% нь ажлын туршлагагүй, 18.2% нь тогтвор суурьшилгүй, 17.1% нь ажлын нөхцөл, цалин хөлсөө голдог гэжээ. Энэ мэтчилэн залуучууд, тэр дундаа шинэ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэхэд тулгардаг бэрхшээлийг бууруулах, залуучуудыг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, ажил олгогч нартай холбож өгөх үүднээс Зориг сан уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх санаачилгыг гаргажээ. Эхний удаагийн хөтөлбөрийн хэрэгжилтийн амжилтын хувиас хамаарч дараагийн жилийн хөтөлбөрт өөрчлөлт оруулж, улам бүр чамбайруулах үүднээс хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээг хийлгэсэн юм.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Зориг сангаас хэрэгжүүлсэн уг хөтөлбөрт нийт 19 оролцогч хамрагдсан бөгөөд нийтдээ 5 сарын хугацаанд гурван үе шатаар хэрэгжсэн.



Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд тоон болон чанарын судалгааны аргыг ашигласан бөгөөд 7 төрлийн хэрэглэгдэхүүнийг боловсруулж хөтөлбөрийн үе шат тус бүрд мэдээлэл цуглуулсан.

## ҮР ДҮН

Хөтөлбөрийн үнэлгээний зарим гол үр дүнгээс дурдвал:

- “Залуусын тогтвортой ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” нь их дээд сургуулийн оюутнаас хөдөлмөрийн зах зээлд ажиллах

хүч болон шилжиж буй залуучуудын хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн шинэлэг хөтөлбөр байж чадлаа. Хөтөлбөр хэрэгжүүлэгчид хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн өмнө нийт 12 зорилгыг тавьсан байснаас хөтөлбөрийн төгсгөлд 10-ыг нь давуулан биелүүлсэн үзүүлэлттэй



байв.

- Хөтөлбөрт хамрагдагч залуусын хөдөлмөрийн зах зээлийн талаар мэдлэг мэдээлэл, ажлын байранд шаардагддаг ур чадваруудын хувьд эерэг өөрчлөлт гарсны үр дүнд хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс 3 сарын дараа нийт оролцогчдын 68.4% нь бүтэн цагийн ажилд орж хөдөлмөр

эрхэлж эхэлсэн бол хөтөлбөрийн төгсгөлд энэ тоо 78.9% болж өссөн үзүүлэлттэй байв. Хөтөлбөрийн явцад ажлын байранд шаардагддаг 14 төрлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилготой сургалтууд олгогдсон бөгөөд сургалтын өмнө болон дараах оролцогчдын мэдлэг, ур чадварт гарсан өөрчлөлтүүдийг Дүрс 1-т харуулав.

Дүрс 1. Хөтөлбөрийн хүрээнд олгосон сургалтын үр дүнд оролцогчдын мэдлэг, ур чадварт гарсан өөрчлөлт



- Нийт 5 сарын хөтөлбөрийн 3 дахь сараас эхлэн албан байгууллагуудтай хөтөлбөрт оролцогчдыг холбож, ажилд зуучилсан бөгөөд тэдгээр байгууллагын 76.4% нь цаашид Зориг сантай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх саналаа илэрхийлсэн зэрэг нааштай үр дүнгүүд гарсан.

## ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ


Залуусын тогтвортой ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн эхний шатны хэрэгжилтийн үр дүнд үндэслэн хоёр дахь удаагийн хөтөлбөр 2019 оны 10-р сарын 14-ний өдрөөс эхлэн

хэрэгжиж байгаа бөгөөд цаашдын хөтөлбөрийн үнэлгээг хөтөлбөр хэрэгжүүлэгчид бие даан хийх юм. Төслийн хүрээнд боловсруулсан хэрэглэгдэхүүнүүдийг дараагийн хөтөлбөрүүдэд бүрэн ашиглах боломжтой ба үнэлгээний хэрэглэгдэхүүнийг хэрхэн сайжруулах, хэрэглэгдэхүүн боловсруулахдаа юуг анхаарах, мэдээллийг хэрхэн цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх талаар төслийн баг зөвлөгөө өгч ажиллалаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Зориг сангийн хамт олонд болон цаашдын хөтөлбөрт оролцогчдод IRIM судалгааны хүрээлэнгээс өндөр амжилт хүсье.

# ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ИРГЭДИЙН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙН ЖЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭ



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Азийн Сан

## САНХҮҮЖҮҮЛЭГЧ

Швейцарын хөгжлийн агентлаг

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү судалгааны зорилго нь (i) төрийн захиргааны тодорхой үйлчилгээнүүдийг авахад гэр хорооллын зорилтот бүлгийн иргэдэд тулгарч буй хүндрэл бэрхшээлүүд, хүртээмжийн одоогийн түвшнийг тодорхойлох; (ii) хүртээмжтэй байдалд нөлөөлж буй хүчин зүйлсэд нарийвчилсан шинжилгээ хийх; (iii) эдгээр үйлчилгээнд жендерийн мэдрэмжийн үнэлгээ хийх; (iv) Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (НЗДТГ)-т төрийн үйлчилгээг боловсруулахдаа жендерийн мэдрэмж, тэгш байдлын зарчмуудыг тусгахад нь санал зөвлөмж боловсруулахад оршино.

Уг судалгааны хүрээнд дараах гол асуултуудад хариулахыг зорилоо. Үүнд:

1. Төрийн захиргааны үйлчилгээний хүртээмж, хүрэлцээтэй холбоотой ямар бэрхшээлүүд байна вэ?
2. Төрийн захиргааны үйлчилгээний загвар, хэрэгжилт нь жендерийн мэдрэмжтэй юу?
3. Эрэлттэй холбоотой ямар хүчин зүйлс эдгээр бэрхшээлд нөлөөлж байна вэ?
4. Нийлүүлэлттэй холбоотой ямар хүчин зүйлс эдгээр бэрхшээлд нөлөөлж байна вэ?
5. Энэхүү бэрхшээлүүдийг бууруулж, холбогдох хүчин зүйлийг багасгахын тулд юу хийх шаардлагатай вэ?



# 2019

1-р сар

# 2019

9-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хотын 7 дүүргийн 11 хороо

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Азийн Сан нь НЗДТГ-тай хамтран Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Хотын засаглалыг сайжруулах төсөл (ХЗСТ)-ийг хэрэгжүүлж байна. Төслийн эхний үе шат нь 2015-2019 оны хооронд хэрэгжсэн бөгөөд гол зорилго нь гэр хорооллын иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн олон нийтийн үйлчилгээ болон хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хүргэх чадавхыг бэхжүүлэхэд нийслэлийн захиргааны байгууллагад дэмжлэг үзүүлэх явдал юм. Ингэхдээ ядуурлыг бууруулах, хүйсийн тэгш байдлыг хангах зарчмыг баримтлан ажиллаж байна.

Зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн чанартай төрийн үйлчилгээ нь Улаанбаатар хотын гэр хорооллын ядуурал, тэгш бус байдлыг бууруулахад ихээхэн ач холбогдолтой юм. Чанартай төрийн үйлчилгээ гэдэг нь төлөвлөлтөөс эхлээд хэрэгжүүлэлт, хяналт, мониторингийн гэх мэт бүх шатандаа хүрэлцээтэй, хүртээмжтэй, хариуцлагатай, жендерийн мэдрэмжтэй төрийн үйлчилгээг хэлнэ (ActionAid 2018). Улаанбаатар хотод зорилтот бүлгүүд онцлогтоо тохирсон интервенц, төрийн үйлчилгээнд хамрагдахын тулд захиргааны үйл ажиллагааны анхан шат болох өөрсдийн харьяа хороонд хандах шаардлагатай байдаг. Хороод нь төрөөс үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг иргэдэд хүргэх, анхан шатны үйлчилгээг үзүүлдгээрээ төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгоход голлох үүргийг хүлээн ажилладаг (World Bank 2017).

Гэвч гэр хорооллын зорилтот бүлгийн иргэдэд тулгардаг бодит бэрхшээлүүдтэй холбоотой тодорхой бус байдлууд байсаар байна. Төрийн үйлчилгээний хүртээмж, ялангуяа төрийн захиргааны үйлчилгээ, эдгээр үйлчилгээг авахад тулгардаг бэрхшээлүүд нь жендертэй холбоотой эсэх нь тодорхой бус байна.

Түүнчлэн иргэдийн нийгэм эдийн засгийн хүчин зүйлс (эрэлт талаасаа), эсвэл тухайн төрийн үйлчилгээний загвар, хэрэгжүүлэлтийн чанартай холбоотой хүчин зүйлс (нийлүүлэлт талаасаа) нь эдгээр бэрхшээлд хэрхэн нөлөөлдөг, хүчин зүйлс хоорондоо хэрхэн харилцан нөлөөлдөг зэрэг нь өдий хүртэл тодорхойгүй байна. Улаанбаатар хотын дүүрэг, хороодын төрийн захиргааны үйлчилгээтэй холбоотой жендерийн үнэлгээ урьд өмнө хийгдээгүй байна.

Энэ орон зайг нөхөж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгоход тулгарч буй бэрхшээлийг бууруулах үр өгөөж бүхий стратеги боловсруулахад нь НЗДТГ-т дэмжлэг үзүүлэх зорилгоор Азийн сангийн ХЗС төсөл болон Швейцарын хөгжлийн агентлагийн захиалгаар IRIM судалгааны хүрээлэн Улаанбаатар хотод оршин суудаг зорилтот бүлгийн иргэдийн дунд төрийн үйлчилгээний хүртээмжийн жендерийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.. Энэхүү судалгаа нь хорооны түвшинд зорилтот бүлгийн иргэдийн төрийн үйлчилгээг авахтай холбоотой туршлагын талаар тоон мэдээллээр хангахын сацуу зорилтот бүлгүүдийн төрийн үйлчилгээг хүртэхэд учирч буй бэрхшээлүүдийг тодорхойлж, тэдгээр бэрхшээлд иргэдийн буюу эрэлтийн талаас, төрийн үйлчилгээний буюу нийлүүлэлтийн талаас нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлсноороо онцлог юм.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Жендерийн мэдрэмжтэй төрийн үйлчилгээ (ЖМТҮ) (ActionAid 2018), Тэгш байдалд төвлөрсөн, жендерийн мэдрэмжтэй үнэлгээ (UN-Women 2016)-ний хүрээнд 6 шалгуур үзүүлэлт бүхий аналитик хүрээг тодорхойлж уг судалгаанд ашиглалаа. Үүнд:

- Хүрэлцээ;

- Нийгмийн хүртээмж (мэдлэг);
- Нийгмийн хүртээмж (хандлага);
- Биет хүртээмж;
- Хариуцлага;
- Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт

Норматив мэдэгдлүүд (дэд шалгууруудыг илэрхийлэх), асуумж дахь олон сонголтод

асуултууд, мэдлэг шалгах тестүүд, төрийн албан хаагчдаас цуглуулсан ярилцлагын мэдээлэл зэргийг ашиглан судалгааны тодорхой дүрмүүдийг боловсруулсан. Дараах зурагт төрийн үйлчилгээний хүртээмжид нөлөөлөх хүчин зүйлс болон зорилтот бүлгийн иргэдэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг хэрхэн тодорхойлсныг харуулав.

Дүрс 2. Судалгааны аналитик хүрээний хураангуй



Холимог судалгааны аргаар судалгааг хэрэгжүүлсэн бөгөөд анхдагч мэдээллүүдийг дараах аргуудаар цуглууллаа. Үүнд:

- Төрийн захиргааны үйлчилгээний хүртээмж, тэдгээрийн жендерийн мэдрэмжийн талаар иргэдээс асуумж судалгаа авсан. Нийт Улаанбаатар хотын 7 дүүргийн 11 хорооны 385 иргэн судалгаанд хамрагдав.
- Хагас бүтэцлэгдсэн ярилцлагын аргаар нийслэл, дүүрэг, хорооны 20 албан хаагчтай ярилцлага хийхийн сацуу 74 төрийн албан хаагчаас жендерийн болон бусад тэгш байдлын зарчмын талаарх мэдлэг, хандлагыг нь тодорхойлох тест авлаа.
- Нийслэл, дүүрэг, хорооны төрийн

үйлчилгээний 15 байранд ажиглалт хийж, хяналтын хуудас бөглөсөн. Хяналтын хуудсанд төрийн үйлчилгээний байрнуудын гаднах болон доторх биет хүртээмжийг үнэлэх асуултуудыг багтаав.

- Судалгаанд нийслэл болон хорооны түвшинд ашиглагдах холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд, жилийн тайлан, үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг ашиглалаа.

Дүн шинжилгээг 'тодорхойлох статистик' болон 'хүчин зүйлийн шинжилгээ'-ээр боловсруулсан. Жендерийн ялгаатай байдал (болон тэгш байдал), эдгээрийн нийгмийн бусад үзүүлэлтүүдээс (тухайлбал, нийгмийн давхарга, орлого, яс үндэс, бэлгийн чиг

хандлага гэх мэт) хэрхэн хамаарч буйг олон хүчин зүйлийн шинжилгээний аргаар үнэллээ.

## ҮР ДҮН

Төрийн үйлчилгээ авахад бэрхшээлтэй тулгардаг эсэхийг асуухад судалгаанд хамрагдсан зорилтот бүлгийн оролцогчдын 85% нь хамгийн сүүлд үйлчилгээ авахад ямар нэгэн бэрхшээлтэй тулгараагүй гэж хариулсан бол 15% нь бэрхшээлтэй тулгарсан гэжээ.

Бэрхшээлтэй тулгарсан хүмүүсийн гуравны нэг орчим нь хүссэн үйлчилгээгээ авч чадаагүй байна. Бусад бэрхшээлийн хувьд төрийн албан хаагчтай харьцахад хүндрэлтэй байдаг, төрийн үйлчилгээний мэдээллийн хангалтгүй байдал, төрийн албан хаагчийн үл хүндэтгэсэн харьцаа, төрийн байгууллагын байршил, төрийн байгууллагад хүрч очих нийтийн тээврийн чиглэл ба хүрэлцээ, төрийн үйлчилгээний зардал зэрэг хүртээмжтэй холбоотой саадуудыг дурдсан байна.

### Үр дүн 2

#### Судалгаанд оролцогчдоос төрийн үйлчилгээ авахад бэрхшээлтэй тулгардаг эсэхийг асуухад



ЖМТҮ-ний аргачлалын дагуу төрийн үйлчилгээний хэрэгжилт, хүрэлцээ, хүртээмжийг нарийвчлан үнэлсэн бөгөөд үнэлгээний үр дүнг ерөнхийлөн дүгнэвэл төрийн захиргааны байгууллагын үйлчилгээний жендерийн мэдрэмж нь засаглал болон төрийн үйлчилгээг хүргэх загвар/механизмын хувьд хамгийн сул байна. Зургаан шалгуур үзүүлэлтээс гурав нь суурь, нэг нь дунд, хоёр нь сайн гэсэн түвшинд тус тус үнэлэгджээ.

- **Хүрэлцээт байдлын** шалгуур үзүүлэлт сайн түвшинд үнэлэгдлээ. Энэ нь төрийн үйлчилгээг тоо хэмжээ болон эдийн засгийн хувьд зорилтот бүлгүүд хүртэх боломжтой эсэх, үйлчилгээний мэдээлэл зорилтот бүлгүүдэд хүрч чадаж байгаа эсэхийг хэмжсэн. Залуучууд болон

хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс бусад бүлгүүд үйлчилгээний үнийг боломжийн гэжээ.

- Төрийн албан хаагч болон иргэдийн нийгмийн хүртээмжийн талаарх **мэдлэг** суурь түвшинд үнэлэгдлээ. Төрийн албан хаагчдаас авсан тестийн үр дүнгээс харахад дүүргүүдийн нэг цонхны үйлчилгээ болон хорооны ажилтнуудын зорилтот бүлгийн иргэдийн эрэлт хэрэгцээ, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ЛГБТ хүмүүсийн онцлог, хэрэгцээ шаардлагын талаарх мэдлэг бага байв. Түүнчлэн төрийн албан хаагчидтай хийсэн ярилцлагаар албан хаагчдад тохирсон сургалт хангалтгүйн дээр давтамж нь бага байдаг нь

илэрсэн. Харин судалгаанд оролцсон иргэдийн тал хувь нь үйлчилгээ авахтай холбоотой эрхийнхээ талаар мэдлэггүй болохоо илэрхийлжээ.


- Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төв, дүүргийн нэг цэгийн үйлчилгээний төв болон хорооны ажилчдын **хандлага, харилцааг** илэрхийлэх нийгмийн хүртээмж сайн түвшинд үнэлэгдлээ. Судалгаанд оролцогчдын олонх нь (75%) төрийн албан хаагчдыг үйлчилгээ үзүүлэхдээ ялгаварлан гадуурхдаггүй гэсэн бол 25% нь ялгаварлан гадуурхалт мэдэрсэн гэжээ. Ялгаварлан гадуурхалт өртсөн гэж хариулсан хүмүүсийн ихэнх нь эмэгтэйчүүд, залуучууд, ганц бие өрх толгойлсон иргэд байв.
- **Биет хүртээмжийг** асуулга судалгаа, ажиглалтын хуудсанд үндэслэн үнэлсэн бөгөөд энэ нь дундаж түвшинд үнэлэгдэв. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнууд биет хүртээмжийг хамгийн сул гэж үнэлсэн бөгөөд үүнийг

эрс сайжруулах шаардлагатай байгааг дурдаж байв. Ялангуяа харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан 'явган замын товгор чиглүүлэгч', 'том фонтоой бичиг эсвэл брайл үсгээр бичсэн мэдээллүүд', 'хашлага бүхий налуу зам' зэргийг төрийн байгууллагуудын үйлчилгээний байранд байршуулах шаардлагатай байна.

- Хамгийн бага түвшинд буюу суурь түвшинд үнэлэгдсэн шалгуурууд нь төрийн захиргааны үйлчилгээний загвар/механизмтай холбоотой байв. Эдгээр нь **хариуцлага, төсөвлөлт** юм. Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн шалгуур үзүүлэлт нь ЖМТҮ-ний аргачлалтай хамгийн бага нийцсэн ба төсөв төлөвлөлтийн бүхий л үе шатанд (төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалт, тайлагнал) жендерийн индикаторууд, хүйсээр ангилсан өгөгдлийг ашиглах явдал улсын болон орон нутгийн түвшиндээ аль алинд нь бага байна.

# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ СУРГАЛТ

 The Asia Foundation

 Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Азийн Сан болон Швейцарын хөгжлийн агентлаг

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ) хийх талаар онол, арга зүй, олон улсын туршлага хосолсон цогц мэдээлэл олгох, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилготой байв.



# 2019

6-р сар

# 2019

9-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хот

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Азийн Сан нь НЗДТГ-тай хамтран Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Хотын засаглалыг сайжруулах төсөл (ХЗСТ)-ийг хэрэгжүүлж байна. Төсөл нь иргэдийн санал хүсэлтийг нийслэлийн шийдвэрт тусгахад дэмжлэг үзүүлэх, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг сайжруулах, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх гэсэн үндсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй.

Бүрэлдэхүүн 3-ын хүрээнд нийслэл, дүүрэг, хороодын төрийн захиргааны албан хаагчдын иргэдэд мэргэжлийн түвшинд чанартай үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай чадавх бэхжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Энэ хүрээнд Нийслэлийн Архивын газар, түүний харьяа байгууллагын ажилтнуудад зориулан “Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Мөн уг сургалтын дараа орон даяар “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг” болохоор төлөвлөгдсөн тул сургалтыг улсын үзлэгийн удирдамжтай уялдуулах хэрэгцээ шаардлагатай нийцүүлэн сургалтыг зохион байгуулав.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Сургалт зохион байгуулахаас өмнө сургалтын хэрэгцээ тодорхойлох асуулгыг оролцогчдоос авсан бөгөөд асуулгын үр дүн, захиалагчийн саналд үндэслэн ХШҮ-ний гол таван сэдвийн хүрээнд сургалтын хөтөлбөр болон найман төрлийн сургалтын танилцуулгыг бэлтгэж ашиглалаа. Сургалтыг лекц, дасгал ажил, нээлттэй хэлэлцүүлэг зэрэг аргуудыг хослуулан зохион байгуулсан бөгөөд дараах сэдвийн дагуу багаар ажиллаж, үр дүнг хэлэлцүүлээ. Үүнд:

- Багийн ажил-1. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн төлөвлөлт, тайлагналт
- Багийн ажил-2. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинээр төлөвлөх
- Багийн ажил-3. Нэгжийн түвшний гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлагналт
- Багийн ажил-4. Байгууллагын түвшний гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлагналт
- Багийн ажил-5. Нийслэлийн баримт бичиг шийдвэрлэлтийг сайжруулах зорилт

Уг ажилбарт оролцогчид идэвхтэй оролцож, бодитой үр дүнтэй байсныг дурдаж байв.

## ҮР ДҮН

Сургалтад Нийслэлийн Архивын газрын 13 албан хаагч, дүүргийн архивын тасгийн 18 албан хаагч, буюу нийт 31 төрийн албан хаагч оролцлоо. Сургалтын эхэнд болон төгсгөлд оролцогчдоос ХШҮ-ний талаар суурь мэдлэгийн тест авч харьцуулахад сургалтын дараах мэдлэгийн түвшин дунджаар 93%-иар өссөн. Тодруулбал, сургалтын төгсгөлд үндсэн таван сэдвийн асуултад бүгдэд нь зөв хариулсан оролцогчдын тоо өсөхийн сацуу тэдний “Шалгуур үзүүлэлт тодорхойлох” мэдлэг хамгийн ихээр нэмэгдсэн байв. Түүнчлэн “Хяналт-шинжилгээ болон үнэлгээний ялгааны талаарх” мэдлэгийг эзэмшсэн оролцогчдын тоо мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн. Харин “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд ХШҮ хийх нийтлэг журам”-ын талаарх оролцогчдын мэдлэг сургалтын эхэнд сайн байсан ба сургалтын үеэр өөр хоорондоо хэрэгжүүлэхтэй холбоотой туршлагаа солилцлоо (Дүрс 1).



Дүрс 1. Сургалтын өмнө болон дараах мэдлэг шалгах тестийн үр дүн /зөв хариулт өгсөн хүний тоогоор/



## ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

ХШҮ-ний чадавх, мэргэжилтнүүдийн ур чадварыг сайжруулах чиглэлээр ямар ажил нэн түрүүнд хийх шаардлагатай байгааг оролцогчдоос тодруулахад Нийслэлийн захиргааны байгууллагын ХШҮ-ний ерөнхий чадавх бэхжүүлэх ажлыг цааш үргэлжлүүлэх нэн шаардлагатай төдийгүй ХШҮ-ний мэргэжилтнүүдийг ажлын байран дээр нь дадлагажуулах(workplace coaching) хөтөлбөрийг хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй талаар саналаа илэрхийлж байв.

Тодруулбал, гуравны нэг орчим (30%) нь ХШҮ-ний сургалтыг тогтмол хийж,

хариуцсан мэргэжилтэн болон удирдлагад мэдлэг чадвар олгох шаардлагатай гэж үзсэн.Түүнчлэн ХШҮ-ний мэргэжилтний орон тоог нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай болгох (12%), төрийн захиргааны (нутгийн удирдлагын) байгууллага үйл ажиллагаандаа бодит төлөвлөлт хийх (8%) гэсэн саналуудыг гаргасан байна. Цөөн тооны оролцогч шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлох, ХШҮ-ний үйл ажиллагаанд удирдлага саналаа өгөх, хяналтаа сайн тавих, төлөвлөлт хийхэд мэргэшүүлэх, тасралтгүй сургах зэрэг(8%) саналууд тус тус гаргаж байв.

# ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХАД ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ (ИНБ) ЧАДАВХЖУУЛАХ ТӨСӨЛ



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

IRIM судалгааны хүрээлэн

## САНХҮҮЖҮҮЛЭГЧ

Innovation for Change

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн зорилго нь төрийн байгууллагуудын цахим ил тод байдлыг хэмжих индексийн туршилтын хувилбарыг боловсруулах явдал байв. Ингэхдээ ИНБ-уудыг татан оролцуулж, индексийг тооцох аргазүйд сургах цаашлаад үр дүнд үндэслэн төрийн байгууллагуудыг санал зөвлөмжөөр хангах юм.



# 2019

4-р сарын 15


# 2019

8-р сарын 23

Хурал зохион байгуулах төсөл нь 2017 оны 9 сараас 2018 оны 8 сар хүртэл үргэлжилсэн. Хурлын нэрэмжит эрдэм шинжилгээний сэтгүүл боловсруулах төсөл 2018 оны 9 сараас 2019 оны 8 сар хүртэл үргэлжилнэ.

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол болон Киргизстан улсаас тус бүр дээд түвшний 20 төрийн байгууллагыг хамрууллаа.



## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

IRIM судалгааны хүрээлэн 2010 оноос хойш төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг үнэлэх зорилгоор ‘Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал’ мониторинг судалгааг гүйцэтгэсээр ирсэн билээ. Уг үнэлгээг олон улсын түвшний индекс болгох санаачилга гарган аргазүйгээ шинэчилж, төрийн байгууллагын “Цахим ил тод байдлын индекс”-ийг боловсрууллаа. Уг индексийг турших, сайжруулах ажлыг Киргизстан Улсын нийслэл Бишкек хотноо 7-8 сард зохион байгуулав.

Индексийн гол онцлог бол зөвхөн цахим мэдээллийн ил тод байдлыг үнэлэх бус мэдээллийн ил тод байдлыг сайжруулахад шаардлагатай хууль эрх зүй орчин, засаглал, иргэний нийгмийн идэвх оролцоо бүрдсэн

эсэхийг цогцоор нь харахын зэрэгцээ тухайн төрийн байгууллагад мэдээллийг ил тод болгох чадавх, нөөц, механизм байгаа эсэхийг үнэлэх явдал юм.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Цахим ил тод байдлын индекс нь төрийн байгууллага, тэдгээрийн нэгжүүдийн цахим мэдээлэл түгээхтэй холбоотой асуудалд түлхэц үзүүлэх, ил тод ба нээлттэй байх соёлыг хөгжүүлэхэд цахим мэдээллийн ил тод байдал хэрхэн чухал үүрэг гүйцэтгэдгийг мэдээлэх үүрэгтэй юм. Уг индекс нь дараах зурагт харуулснаар 3 үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй.

## ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКС



Индексийг боловсруулахад төслийн баг дараах гурван үе шаттайгаар ажилласан. Үүнд:

1. Төв Азийн төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдлын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж олон улсын үнэлгээний аргазүй, санаачилгуудыг судлан цахим ил тод байдлын индексийн туршилтын хувилбарыг боловсрууллаа.
2. Цахим ил тод байдлын индексийн туршилтын хувилбарыг Киргизстан болон Монгол улсад амжилттай хэрэгжүүллээ. Ингэхдээ Киргизстаны ИНБ-тай хамтран ажилласан.
3. Цахим ил тод байдлын индексийг

цаашид олон улс оронд туршин нэвтрүүлэх зорилгын хүрээнд Төв Азийн долоон орны ИНБ-уудад индексийг боловсруулах аргазүйн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

### ҮР ДҮН

Монгол Улсын хэмжээнд төрийн байгууллагуудын цахим ил тод байдал сул түвшинд үнэлэгджээ. Тодруулбал, МУ-ын төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын индекс нь 1 онооноос 0,621 авсан байна. Индексийг бүрэлдэхүүнээр нь задалж харвал Эрх зүйн орчин 0,657 оноо, Байгууллагын чадамж 0,686 оноо, Цахим нээлттэй байдал 0,520 оноог тус тус авчээ.

Эрх зүйн орчин		Байгууллагын чадамж		Цахим нээлттэй байдал	
Индекс	Төлөө	Индекс	Төлөө	Индекс	Төлөө
0,621	Сүүлчийн үеийн хөгжлийн төлөв	0,686	Мэргэжлийн үнэлгээ	0,520	Сүүлчийн үеийн хөгжлийн төлөв
0,657	Эрх зүйн орчин	0,686	Байгууллагын чадамж	0,520	Цахим нээлттэй байдал
0,657	Эрх зүйн орчин	0,686	Байгууллагын чадамж	0,520	Цахим нээлттэй байдал
0,657	Эрх зүйн орчин	0,686	Байгууллагын чадамж	0,520	Цахим нээлттэй байдал
0,657	Эрх зүйн орчин	0,686	Байгууллагын чадамж	0,520	Цахим нээлттэй байдал

Киргизстан улсын хувьд төрийн байгууллагуудын цахим ил тод байдал мөн сул түвшинд үнэлэгдсэн байна. Тодруулбал, Киргизстаны төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын индекс нь нийтдээ 0,506 буюу МУ-ынхаас 0.115

пунктээр доогуур үнэлэгдсэн байна. Индексийн бүрэлдэхүүн хэсгээр нь авч үзвэл Эрх зүйн орчин 0,590 оноо, Байгууллагын чадамж 0,612 оноо, Цахим нээлттэй байдал 0,315 оноог тус тус авчээ.

КИРГИЗСТАН 0,506											
Төрийн гэрээ				Байгууллагын гэрээ				Төрийн цахим талбай			
0,506				0,512				0,315			
Бүрэлдэхүүн хэсэг	Урьдчилсан үнэлгээ	Төгсгөл үнэлгээ	Эрх зүйн орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал	Эрх зүйн орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал	Эрх зүйн орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал
Мэдээллийн систем	0,300	0,319	0,325	0,275	0,275	0,275	0,275	0,275	0,275	0,275	0,275
Мэдээллийн систем	0,300	0,319	0,325	0,275	0,275	0,275	0,275	0,275	0,275	0,275	0,275
Мэдээллийн систем	0,300	0,319	0,325	0,275	0,275	0,275	0,275	0,275	0,275	0,275	0,275
Мэдээллийн систем	0,300	0,319	0,325	0,275	0,275	0,275	0,275	0,275	0,275	0,275	0,275

## ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Индексийн туршилтын хувилбарын үр дүнг Киргизстан Улсын нийслэл Бишкек хотноо амжилттай танилцууллаа. Нээлтийн үйл ажиллагаанд оролцсон Төв Азийн долоон

орны төлөөлөгчид уг индексийг өөрсдийн улсдаа туршин, нэвтрүүлэх нэн шаардлагатайг илэрхийлээд байна.

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, НҮБ-ЫН ХҮҮХДИЙН САНГИЙН ХАМТАРСАН 2012-2016, 2017-2021 ОНУУДЫН УЛС ОРНЫ ХӨТӨЛБӨРИЙН БОЛОВСРОЛЫН ҮР ДҮНГИЙН ХАМРАН СУРГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГТ ХИЙХ ҮНЭЛГЭЭНИЙ ТӨСӨЛ



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан (НҮБХС)

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү үнэлгээний зорилго нь 2012-2018 онуудад улс орны өмнөх болон одоогийн хөтөлбөрийн хугацаанд Суурь Боловсролын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн “Хамран сургалтын боловсрол хөтөлбөр”-ийн үр дүнг үнэлэх юм. Тодорхой зорилтуудад:

- a. Хамран сургалтын бодлогын орчныг сайжруулах чиглэлээр бодлогын түвшинд НҮБ-ийн Хүүхдийн сангийн оролцооны байдлыг үнэлэн дүгнэж, засгийн газрын үндсэн бодлогын түвшинд хийх өөрчлөлт болон Монгол дахь НҮБ-ийн Хүүхдийн сангийн цаашдын холбогдох үйл ажиллагааны талаар санал, зөвлөмж гаргана.
- b. Багш бэлтгэх сургуульд сурч байгаа болон ажиллаж байгаа багш нарын сургалтын хөтөлбөрийг хянан үзэж, түүнийг сайжруулахад НҮБ-ийн Хүүхдийн сангаас үзүүлсэн техникийн туслалцаа, тэрчлэн, багш бэлтгэх институт ерөнхий боловсролын жирийн сургуулиудтай холбогдож, хамран сургалтын хүрээн дэх тусгай боловсролыг дэмжсэн үйл ажилд үнэлгээ дүгнэлт хийн, цаашид Боловсролын их сургууль, Багш нарын мэргэжил дээшлүүлэх институтээс сайжруулах шаардлагатай асуудалд НҮБ-ын Хүүхдийн сангийн цаашдын оролцооны талаар санал, зөвлөмж боловсруулж гаргана.
- c. Газар зүйн зорилтот байршлуудад НҮБ-ын Хүүхдийн сангаас хэрэгжүүлсэн ерөнхий боловсрол олгох хамран сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийж, одоо хэрэгжиж буй загварыг сайжруулах, бусад сургууль, аймагт түгээн дэлгэрүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулж гаргана.
- d. Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сангийн бүх салбар хөтөлбөрүүдэд хамран сургалтыг сайжруулах талаар болон бага насны хүүхдийн боловсрол хөгжил болон суурь боловсролын бүрэлдэхүүн хэсэг хоорондын уялдаа, залгамж холбоог сайжруулах талаар тусгай зөвлөмж боловсруулан гаргана.
- e. Монголын бүх нийтээр боловсрол эзэмших төлөвлөгөөнд НҮБ-ын Хүүхдийн сангаас оруулж буй нэмэлт хувь нэмрийг үнэлэн дүгнэнэ.




# 2019

2-р сар

# 2019

6-р сар

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



*Хөвсгөл, Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймаг болон Улаанбаатар хотод хэрэгжсэн.*

### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан (НҮБХС) болон Монгол Улсын Засгийн Газар 2012-2016 болон 2017-2021 онуудад Улсын Орны Боловсролын Хөтөлбөрийн Боловсролын үр дүнгийн хамран сурган бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлсэн. 2013/2014-2016 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн санаачилгаар тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай байгаа хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах үүднээс хамрах сургах боловсролын туршилт загварыг зорилтот Хөвсгөл аймагт болон Налайх дүүрэгт байгуулсан. Уг туршлагаа түгээн дэлгэрүүлэх үүднээс 2016-2018 онд зорилтот 3 аймаг болон Баянзүрх дүүрэгт төсөл хэрэгжсэн.

### ТӨСЛИЙН ДИЗАЙН

Үнэлгээний хувьд Үндэстний Хөтөлбөрийн зорилтот газрууд болох Хөвсгөл, Баянхонгор, Говь-Алтай болон Завхан аймгууд болон Налайх, Баянзүрх дүүргүүдэд мэдээлэл цуглуулах ажлууд хийгдсэн. Төсөл хэрэгжилтийн шатанд

төслийн баг төсөл хэрэгжүүлэгч байгууллага, тэгш хамран сургах чиглэлээр ажилладаг хувь хүн, байгууллагуудтай уулзалт хийхээс гадна төслийг хэрэгжүүлэгч, үр шим хүртэгч нар буюу сургуулийн захирал, менежер, нийгмийн ажилтан, багш нар, Хүүхэд Хөгжлийн Төвийн багш, эцэг эх нартай дараах ажлуудыг хийсэн. Тодруулбал:

- Төслийн оролцогч талуудтай ярилцлага
- Анги болон сургуулийн нөхцөл байдал, тэгш хамран сургах хүртээмжийг үнэлэх ажиглалтууд
- Тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэх өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй асуудлын талаар ИНБ-уудтай бүлгийн ярилцлага

### ҮР ДҮНГҮҮД ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Төслийн үр дүнд, тэгш хамрах сургах боловсролын одоогийн нөхцөл байдал,

хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, оролцогч талууд, хэрэгжүүлэгч байгууллагын чадавх болон салбарын хэрэгцээ шаардлага, талуудад тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлсон. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх явцад БСШУСЯ, Монголын Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг ТББ, Сонсголгүйн боловсрол ТББ, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Насан туршийн боловсролын төв болон зорилтот сургуулийн төлөөллүүдтэй уулзаж ярилцсан.

Үнэлгээний зорилгын хүрээнд нийтдээ 29 бодлогын бичиг баримт, хуулиудтай танилцан, 150 ганцаарчилсан ярилцлага, 7 бүлгийн ярилцлага хийгдсэн ба 352 хүмүүсээс

шаардлагатай мэдээллийг цуглуулсан байна. НҮБХСангийн дэмжлэгтэй ажилладаг хот болон хөдөө орон нутгийн 12 сургуулиудаас (сургууль болон насан туршийн боловсролын төв) 9 дээр талбарын зочлолт хийсэн. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдэд хамааралтай байдал, үр дүн, үр ашигтай байдал, тогтвортой байдал болон эрх тэгш байдал зэрэг хамаарах ба мэдээлэл боловсруулах явцад мөн ашиглагдсан. Төслийн баг төслийн хэрэгжилтийн үнэлгээний хүрээнд НҮБХСанд 10 зөвлөмж түүнчлэн БСШУСЯ-д 8 зөвлөмжийг тус тус боловсруулан эцсийн тайлан дээр тусгасан.



# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУДЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ ҮНДЭСНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТОГТОЛЦОО БА ЧАДАВХЫН ТОЙМ СУДАЛГАА (КЕЙС СУДАЛГАА)



## SUSTAINABLE DEVELOPMENT GOALS



### ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан (НҮБХС)

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү судалгаа нь “Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ) 2030 хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх Ази, Номхон Далайн бүс нутгийн судалгааны нэг хэсэг бөгөөд Монгол Улсын үндэсний үнэлгээний тогтолцооны чадавхыг тодорхойлж, цаашид сайжруулахад шаардлагатай зөвлөмжийг санал болгох зорилготой хэрэгжсэн. Судалгааны үр дүн бүс нутгийн тайланд нэгтгэгдэж үндэсний ба бүс нутгийн үнэлгээний чадавхыг хөгжүүлэхэд суурь мэдээлэл болгон ашиглагдах зорилготой.

Дээрх зорилгын дагуу судалгааны баг дараах зорилтуудын хүрээнд ажилласан: Үүнд:

1. Үндэсний үнэлгээний тогтолцооны нөхцөл байдал, чадавхад дүн шинжилгээ хийх
2. ТХЗ-2030 хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх тогтолцооны бэлэн байдлыг тодорхойлох,
3. МУ-ын үнэлгээний чадавхтай холбоотой сургамж, туршлага, сорилт, дутагдал, амжилтад хүргэх хүчин зүйлсийг тодорхойлохыг зорьсон.


Түүнчлэн бүс нутгийн бусад орны судалгааны ажлаас ялгаатай нь Монгол Улсын онцлог, нөхцөл байдалтай холбоотойгоор ТХЗ-2030 хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхэд ‘төрийн санхүүгийн удирдлага’, түүнтэй холбоотой харилцааг мөн анхааран авч үзэв.



2019 1-р сар

2019 3-р сар

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хот, Сүхбаатар аймаг

### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

2015 оны 9 сараас эхлэн улс орны төр засгууд “Нийгэм, Эдийн засаг, Байгаль орчин” гэсэн гурван тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх дэлхий дахины үйл ажиллагааны төлөвлөгөө болох ТХЗ-2030 хөтөлбөрийг батлан, нийтээр хүлээн зөвшөөрөн хэрэгжүүлж эхэлсэн билээ. ТХЗ-ын хэрэгжилтийг дэмжихийн тулд олон улс салбар дундын уялдаа холбоогоо сайжруулахад чиглэсэн институтийн зохицуулалтуудыг хэрэгжүүлж, хөгжлийн төлөвлөгөө ба төсвөө ТХЗ-той уялдуулж, улмаар хэрэгжилтээ тасралтгүй хянаж, үнэлэх мэдээллийн системийн чадавх, хүртээмжтэй байдлыг бий болгоход анхаарал хандуулсаар байна. Үүний тулд хэрэгжүүлж буй үйл ажиллагааныхаа хүрсэн үр дүнг хүртээмжтэй, тогтвортой, харилцан хамааралтай байгаа эсэхийг хэмжих, үнэлэх чадавхыг бэхжүүлэх нь улс орнуудын нэн тэргүүнд анхаарч авч үзэх алхам юм.

Манай улс 2016 оны 2 сарын 5-ны өдөр ТХЗ-2030 хөтөлбөрийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн баталсан бөгөөд ядуурал, тэгш бус байдлыг бууруулахад бүх талын оролцоог хангахын чухалчлан тус хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. 2017 оны байдлаар үндэсний болон орон нутгийн түвшинд 162 стратеги, бодлого, хөтөлбөр зэрэг эрх зүйн баримт бичгүүд батлагдсан хэдий ч эдгээр нь улс орны урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдаагүй байхын сацуу хэрэгжүүлэх нөөцийн хуваарилалт болон гүйцэтгэлийг хянах, үнэлэх механизмын хувьд дутагдалтай тал байсаар байна.


Иймд тус судалгааны хүрээнд үндэсний үнэлгээний тогтолцооны чадавхыг бэхжүүлэх, сайжруулах хэрэгцээ шаардлагыг авч үзсэн нь ТХЗ-2030 хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулахад чухал ач холбогдолтой ажил болж буй юм.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Тус судалгааг гүйцэтгэхдээ IRIM судалгааны хүрээлэнгийн баг бүс нутгийн хэмжээнд санал болгосон нэгдсэн арга зүйг ашигласан. Ингэхдээ, доорх зурагт харуулсанчлан “түлхүүр хэлбэр”-тэй судалгааны хүрээг ашиглав.

Тодруулбал, энэхүү судалгаагаар асуудлын ерөнхий хүрээг хамран авч үзсэний дараа нарийвчлан судлах шаардлагатай асуудлуудыг гүнзгийрүүлэн судалсан.

Зураг 1. “Түлхүүр хэлбэр” бүхий судалгааны хүрээ



Дээрх аргазүйн хүрээнд дараах аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулж, шинжилгээ ашиглалаа. Үүнд:


- Хөгжлийн бодлого, хяналт шинжилгээ, үнэлгээтэй холбоотой үндэсний болон олон улсын баримт бичгүүдийг судлах
- Холбогдох төрийн байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл (их дээд сургуулийн багш, мэргэжилтнүүд, үнэлгээний сүлжээний төлөөлөл, ТББ, үнэлгээний мэргэжилтэн, зөвлөхүүд)-ийг оролцуулан нийт 21 байгууллагын төлөөлөлтэй хийсэн 45 гүнзгийрүүлсэн ярилцлага
- 21 аймаг, 13 яамны хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийн дунд явуулсан онлайн судалгаа (Нийт 13 аймаг, 6 яамны төлөөллөөс 35 асуумж бөглөгдөж ирсэн)

- Улаанбаатар хот болон Сүхбаатар аймгийн хяналт шинжилгээ, үнэлгээний албан хаагчдын дунд зохион байгуулсан 3 удаагийн бүлгийн ярилцлага
- Үнэлгээний тогтолцооны гол оролцогч талуудын дунд зохион байгуулсан дугуй ширээний уулзалтуудад үндэслэн үр дүнг нэгтгэв.

## ҮР ДҮН

Үнэлгээний тогтолцооны бэлэн байдлыг тодорхойлоход авч үздэг 7 шалгуур үзүүлэлтийн биелэлтийг үзэхэд манай улсын хувьд бүх үзүүлэлт нь “суурь шат”-аас “хөгжлийн дунд шат” уруугаа явж байгаа буюу дундаж үнэлгээ нь 2.5 оноогоор (1-4 хүртэл шкалаар үнэлүүлэхэд) үнэлэгдлээ. Шалгуур үзүүлэлт тус бүрийн биелэлтийг доор харууллаа:

Дүрс 2. Бэлэн байдлын үнэлгээний нэгдсэн үр дүн



Шалгуур үзүүлэлтүүдээс тогтолцооны гол оролцогч талуудын дунд **“үнэлгээний хэрэгцээ шаардлага”-ыг авч үзэх байдал хамгийн өндрөөр үнэлэгдсэн бол үнэлгээнд шаардлагатай гол “нөөцийн хуваарилалт” хамгийн сул** байна.

Тогтолцооны чадавх бүрдэхэд дээр дурдсан долоон хүчин зүйлс эн тэнцвэртэй хөгжих ёстойг оролцогчид дурдаж байсан ч үүнээс нэн тэргүүнд **“санхүүгийн эх үүсвэр” болон “удирдах түвшний манлайлал”** нь суурь хүчин зүйл буюу хамгийн чухал нөлөөтэй болохыг онцолж байв. Гэвч манай улсын тогтолцоонд дээр дурдсан хоёр хүчин зүйл хамгийн сул байгаа нь үндэсний үнэлгээний тогтолцооны чадавх, түүний хөгжилд шууд нөлөөлж байгаа гэж үзжээ.

Үүнээс гадна манай улсын үнэлгээний тогтолцооны чадавхын сул байдалд нөлөөлж буй гол шалтгааныг аливаа **төсөл хөтөлбөрийн төлөвлөлт болон үнэлгээ хоорондын уялдаа холбоо сул** байдагтай холбон тайлбарлаж байв. Төлөвлөлтийн шатанд өмнөх ажлын үнэлгээний үр дүнг ашигладаггүй, нэгдсэн формат, загваргүй, хууль эрх зүйн бодлогын түвшний уялдаа холбоо сул зэрэг нь үнэлгээний үр нөлөөг бууруулж байна.

Судалгааны дээрх үр дүнгүүд нь бүс нутгийн үнэлгээний тайланд нэгтгэгдэхээс гадна 2019 оны НҮБ-ын дээд түвшний улс төрийн чуулганд МУ-ын засгийн газраас танилцуулсан ТХЗ-ын хэрэгжилтийн “Монгол Улсын үндэсний сайн дурын илтгэл 2019”-ийг боловсруулахад мөн ашиглагдлаа.

# ОРГАНИК ХӨДӨӨ АЖ АХУЙГ ДЭМЖИХ ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГАА



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

АДРА Монгол ОУТББ

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Органик хөдөө аж ахуй (ОХАА) төсөл эхлэхийн өмнө төслийн зорилтот талбар, үр шим хүртэгчдийн нөхцөл байдал, суурь дүр зургийг тодорхойлох зорилготой. Суурь судалгааны хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

- ОХАА-тай холбоотой хууль эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх
- Зорилтот орон нутгийн ОХАА-н салбарын хөгжил, одоогийн нөхцөл байдлыг тодорхойлох
- Төслийн үр шим хүртэгчид болох ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хоршоодын институтчилал, чадавхтай холбоотой нөхцөл байдлыг тодорхойлох
- Хоршоодод гишүүнчлэлтэй иргэд, дэмжигчдийн ОХАА-н талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох
- ОХАА-н чиглэлээр ажилладаг оролцогч талуудын хамтын ажиллагааны нөхцөл байдлыг тодорхойлох зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажилласан.



2019

1-р сарын 7

2019

3-р сарын 31

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Сэлэнгэ аймгийн 11 сумд

### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын хувьд Органик хүнс болон органик хөдөө аж ахуйтай холбоотой асуудал нь шинэ тутам, хараахан хөгжиж амжаагүй салбар юм. Органик хүнсний тухай хуулийг 2016 онд баталж, улмаар органик хүнсний тухай хуулийг хэрэгжүүлэх, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих журмыг батлаад байна. Эдгээр бодлогын баримт бичгийн гол зорилго нь органик хүнс үйлдвэрлэх, боловсруулах, органик хүнсний баталгаат байдлыг баталгаажуулах, бүтээгдэхүүний бүртгэл, органик шошго, хаяг ашиглах зэрэг механизмыг бүрдүүлэхэд оршиж байна.

Органик хөдөө аж ахуйг дэмжих төсөл нь хуулийн хэрэгжилтийг хангуулахын сацуу органик хөдөө аж ахуйн “хамтын баталгаажуулалтын систем”-ийг нэвтрүүлэн хэрэгжүүлэх зорилготой туршилтын төсөл юм. Төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийн 11 суманд байрлаж буй 31 хоршоог чадавхжуулж, нэмүү өртөг шингэсэн, органик бүтээгдэхүүнийг зах

зээлд нэвтрүүлэх замаар ОХАА-н үйлдвэрлэлийг дэмжих үйл ажиллагаа явагдана. Төслөөс хүлээгдэж буй хамгийн чухал үр дүн нь олон талт түншлэлийн механизмыг дэмжиж, “хамтын баталгаажуулалт”-ын системийг нэвтрүүлэх явдал юм.

Уг төсөл нь туршилтын төсөл тул хэрэгжихийн өмнөх суурь нөхцөлөө нарийвчлан тодорхойлох, явцын хяналт, үнэлгээний төлөвлөгөөгөө нягт төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай юм.

### ТӨСЛИЙН ДИЗАЙН

Суурь судалгааны ажлыг зохион байгуулахдаа IRIM судалгааны хүрээлэн нь чанарын болон тоон судалгааны аргыг хослуулан ашиглалаа.

- **Асуумж судалгаа:** Хоршоодод гишүүнчлэл бүхий иргэд, үр шим хүртэгчдээс түүвэрлэн судалгаанд

хамруулав. Уг судалгаагаар хоршоодын гишүүдийн үйл ажиллагааны хэлбэр, зохион байгуулалт, ОХАА-н талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойллоо.


- **Бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага:** Хоршоодын удирдлага, гишүүд, төрийн байгууллагын төлөөлөл, бусад оролцогч талыг хамруулан сум бүрд нэг удаа зохион байгуулсан. Энэ хүрээнд ОХАА-н үйл ажиллагаанд оролцогч талуудын хамтын ажиллагаа, гүйцэтгэж буй үүрэг, цаашдын баримтлах чиглэлийг тодорхойлов.
- **Баримт бичгийн судалгаа:** Холбогдолтой хууль эрх зүйн баримт

бичгүүд болон төсөл хөтөлбөрүүдийг судалж, дүн шинжилгээ хийлээ.

## ҮР ДҮН

Орон нутагт органик хөдөө аж ахуйн үйл ажиллагаа дөнгөж эрчимжиж эхэлж байна. Тодруулбал, судалгаанд оролцогчдын 80 гаруй хувь ямартай ч органик хөдөө аж ахуй гэсэн ойлголтыг сонсож байснаа илэрхийлжээ. Харин “Органик хүнсний тухай хууль”-ийг 45 хувь нь ямар нэгэн байдлаар мэднэ гэж хариулсан бол 55 орчим хувь нэрийг нь мэдэхээс цаашгүй байгаагаа илэрхийлсэн.

Органик хөдөө аж ахуйн талаар сонсож байсан эсэх (n=215)



Судалгаанд оролцогчдын органик хөдөө аж ахуйтай холбоотой мэдлэг, хандлагыг тодорхойлоход 27% нь сайн, 56% нь дундаж, 17% нь муу мэдлэгтэй байна.

Судалгаанд оролцогчдын ОХАА-н талаарх мэдлэгийн байдал		
Мэдлэгийн түвшин	Шалгуур	Хувь
Муу мэдлэгтэй	1-3 асуултад зөв хариулсан	17%
Дундаж мэдлэгтэй	4-6 асуултад зөв хариулсан	56%
Сайн мэдлэгтэй	7-9 асуултад зөв хариулсан	27%

Судалгаанд оролцогчдын олонх нь органик хөдөө аж ахуй гэсэн ойлголтыг сонссон, их бага ямар нэгэн хэмжээнд мэдээлэлтэй байна. ХАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хоршоодын гишүүд энэ талаар мэдээ, мэдээлэл авах хэрэгцээтэй байдгаа илэрхийлсэн бөгөөд

ихэнх нь сургалт, хэлэлцүүлэгт оролцож одоогийн түвшний мэдээлэлтэй болсон байна. Төсөл, хоршооны зүгээс мэдээллээр хангах ажил харьцангуй сайн явагдаж байгаа гэж үзсэн бол төрийн байгууллагын мэдээлэл зөвлөгөөнд сэтгэл ханамж муутай байна.

## ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСЛҮҮД

# ТӨРӨӨС ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ



### ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Эрүүл Мэндийн Яам, Азийн Хөгжлийн Банк

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн зорилго нь төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөг таван дагалдах баримт бичгүүдийн хамт боловсруулах явдал юм. Үүнд, (i) Тусламж, үйлчилгээний нэн шаардлагатай болон нэмэлт багц, (ii) Дунд хугацааны зардлын хүрээ (2019-2024), (iii) Дунд хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон Худалдан авах үйл ажиллагааны явц (iv) Тусламж, үйлчилгээний төлөвлөлтийн хүрээ (2019-2024) (v) Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээ (2019-2024) багтана.






# 2018

4-р сар

# 2020

7-р сар

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



21 аймаг

### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2019-2026)—г боловсруулах техник туслалцааны төслийг Азийн хөгжлийн банк (АХБ), Японы ядуурлыг бууруулах сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна. Техник туслалцааны төсөл нь 2026 он хүртэлх салбарын төлөвлөгөөг боловсруулах сацуу Эрүүл мэндийн яам (ЭМЯ)-ны хүний нөөцийн болон байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Ингэснээр ЭМЯ нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын эрүүл мэндийн зорилтод хүрэх эрүүл мэндийн салбарын хөгжлийн урт хугацааны бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжтой болно.

### ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төслийн хүрээнд баримт бичгүүдийг боловсруулахаа олон төрлийн аргазүйг

ашигласан. Тэдгээрээс олон талт уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах оролцооны аргыг хамгийн түгээмэл ашигласан. Хэлэлцүүлэг, уулзалтуудад эрүүл мэндийн салбарын болон бусад холбогдох салбарын бодлого боловсруулах түвшний удирдах ажилтнуудын төлөөллийн оролцоог тэгш хангаж, тэдгээрээс гарсан саналыг холбогдох баримт бичгүүдэд тусгасан. Мөн эрүүл мэндийн салбарын холбогдох албан тушаалтнууд, мэргэжилтнүүдэд боловсруулсан баримт бичгүүдийг танилцуулах журмаар чадавх бэхжүүлэх сургалтуудыг 2020 оны 4 ба 5 дугаар саруудад зохион байгуулахаар төлөвлөөд байна. Сургалт нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний болон санхүүгийн төлөвлөлт, эрүүл мэндийн үр нөлөө, технологи, хэрэгцээний үнэлгээ, хөрөнгө оруулалт ба хөрөнгийн төлөвлөлт, хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, салбарын зээл, тусламжийн зохицуулалт зэрэг сэдвийг хамарна.

Түүнчлэн салбарын баримт бичгүүдийг боловсруулахдаа Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, түүнийг дагалдах нийтлэг журамд нийцүүлэн боловсруулснаараа онцлогтой.

## ҮР ДҮН, ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (БХАХТ) болон Бодлогыг хэрэгжүүлэх арга зам (БХАЗ)-ын гол зорилго нь 2019-2026 онд Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (ТЭМТББХАХТ)-г гаргахад оршино. Тиймээс тус баримт бичиг нь найман үндсэн чиглэлийн дагуу БХАХТ, БХАЗ гэсэн үндсэн хэсгээс бүрдэнэ.

Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсны дараа Эрүүл мэндийн яам, эрүүл мэндийн бүх түвшний байгууллагын жилийн төлөвлөгөө, төсвийг боловсруулахад эдгээр баримт бичгийг үндсэн чиглэл болгон ашиглах юм.

2020 оны 3 дугаар сарын байдлаар 40 гаруй зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулаад байна. Үүнд бүсийн уулзалт хоёр удаа, үндэсний уулзалт гурван удаа, сэдэвт уулзалтуудыг



давхардсан тоогоор 700 гаруй оролцогчдыг хамруулан зохион байгууллаа. Уулзалтад ЭМЯ, нийслэл болон аймгуудын эрүүл мэндийн газар, нэгдсэн болон төрөлжсөн эмнэлгүүд, мэргэжлийн холбоод, холбогдох яамд, МУ-д суугаа гадаадын элчин сайдын яамд, олон улсын донор байгууллагуудын төлөөлөгчид, бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтнүүд оролцож баримт бичигт саналаа өгч ажиллалаа. Төслийн хүрээнд боловсруулсан баримт бичгүүдээр чадавх бэхжүүлэх сургалтыг зохион байгуулснаар төслийн үйл ажиллагаа дуусах юм.

# ДЭД БҮТЦИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ТАЛУУДЫН ОЙЛГОЛЦОЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ ГОВИЙН ЗАГВАР: МОНГОЛЫН ТУРШЛАГЫГ ТӨВ АЗИД



## GOBI FRAMEWORK FOR SUSTAINABLE INFRASTRUCTURE PARTNERSHIPS



SCALING UP PRAXIS FROM MONGOLIA TO CENTRAL ASIA

ДЭД БҮТЦИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ТАЛУУДЫН ОЙЛГОЛЦОЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ  
БЭХЖҮҮЛЭХ ГОВИЙН ЗАГВАР: МОНГОЛЫН ТУРШЛАГЫГ ТӨВ АЗИД

### ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Их Британи Нэгдсэн Вант Улсын Эдийн засаг, нийгмийн судалгааны хороо, Глобал сорилын судалгааны сан хамтран санхүүжүүлэв.

### ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ

Оксфордын Их Сургууль

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО

БНХАУ-ын томоохон дэд бүтэц, бүтээн байгуулалтын төслүүд хэрэгжиж буй Монгол, Киргизстан, Тажикстан зэрэг улсад эдийн засгийн хөгжил, нийгмийн хамгааллын хүртээмжийг нэмэгдүүлэх “тогтвортой дэд бүтцийг хөгжүүлэх загвар” боловсруулах зорилготойгоор хэрэгжиж байна.

Төслийн зорилт:


- Дэд бүтцийн бүтээн байгуулалтад талуудын ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэх Говийн загвар бий болгож, туршина. Ингэхдээ Монголын Улсын уул уурхайн салбарын туршлагад үндэслэн загварыг хөгжүүлж, Төв Азид нэвтрүүлэх юм. Загварыг БНХАУ-ын ‘Нэг бүс-нэг зам’ (НБНЗ) дэд бүтцийн санаачилга хэрэгжиж буй газруудад ашиглах боломжтойгоор боловсруулахыг зорин ажиллаж байна.
- Дэд бүтцийн томоохон төслүүдийн оролцогч талуудын хоорондох нээлттэй, харилцан итгэлцэл бүхий хамтын ажиллагаанд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлохын сацуу түүнийг даван туулах арга замыг судална.
- Иргэд болон засгийн газрын дэд бүтцийн төслүүдийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, сөрөг үр дагаврыг багасгахад шаардлагатай чадавхыг дээшлүүлнэ.



2018 9-р сар

2021 2-р сар

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Монгол, Киргизстан, Тажикистан

### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Дэд бүтцийн томоохон төслүүд эдийн засгийн өсөлт ба хөгжлийн гол суурь болдог ч нийгэм, байгаль орчинд сөрөг үр дагаврыг бий болгох эрсдэлтэй байдаг. Тухайлбал, орон нутгийн иргэд засаг захиргаатай үл ойлголцох; нөөцийн өрсөлдөөнөөс үүдэн нийгмийн итгэлцэл алдагдах; эдийн засгийн өсөлтийн үр шим тэгш бус хуваарилагдах; засаглал ба институтын чадавх бэхжихгүй байх; байгаль орчны тогтвортой байдал алдагдах; оролцогч талуудын хоорондын зөрчлөөс үүдэн эдийн засгийн үр өгөөж буурах зэргийг дурдаж болно. Эдгээр нийтлэг асуудал тухайн орон нутаг болон түүний газарзүйн онцлогоос хамаарч өөр өөр нөхцөл байдлыг үүсгэдэг. Тиймээс Говийн загвар төсөл эдгээр асуудлыг Төв Ази дахь санаачилгууд, тэр дундаа Нэг Бүс Нэг Зам төслийн хүрээнд нарийвчлан судална.

### ТӨСЛИЙН ДИЗАЙН

Уг төслийн хүрээнд тогтвортой, хүртээмжтэй хөгжлийг бий болгоход талууд хоорондын

зөрчлийг бууруулах, ойлголцол ба хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд засаглалын ямар арга тохиромжтой болохыг олон талт аргаар судалж байна. Энэ хүрээнд Өмнөговь аймгийн Ханбогд суманд 'Гурван талт зөвлөл'-ийн оролцогч талуудын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэхэд ашигласан арга, туршлагын кейсийг судална. Кейс судалгааны үр дүнг "Говийн загвар"-ыг боловсруулахад ашиглах бөгөөд боловсруулсан загвараа Киргизстан, Тажикистан улсад туршина.

Төслийн хүрээнд дараах үр дүнгүүд хүлээгдэж байна. Үүнд:

- Эрдэм шинжилгээний өгүүллэгүүд
- Говийн загварын вэб хуудас
- Гар утасны аппликейшн

Түүнчлэн 2018-2021 онд зөвлөлдөх, мэдлэг солилцох уулзалтуудыг тогтмол зохион байгуулж байна.

### ҮР ДҮН, ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Монгол Улсын гурван суманд (Ханбогд, Сүхбаатар, Гурвантэс сум), Киргизстаны гурван

(Ала-Бука, Нарин, Чаткал дахь) уурхайн зургаан талбайд тус тус анхны судалгаагаа хийгээд байна. Монгол Улсаас нийт 190 ярилцлага, 8 фокус бүлгийн ярилцлага, Киргизстанаас 262 хүнийг судалгаанд (131 ярилцлага, 131 оролцогчтой 33 фокус бүлэг) хамрууллаа. Энэхүү хээрийн судалгаагаар мөргөлдөөний менежмент, нөхөн олговор, компанийн нийгмийн хариуцлага, уул уурхайн нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, мэдлэг оюуны бүтээл, уул уурхайн үйл ажиллагаа, авлига, уул уурхайн ашиглалтын амьдралд үзүүлэх нөлөөллийн талаар чухал шинэ мэдээллийг олж авсан.

Төслийн хүрээнд Монгол Улсын Засгийн Газартай хамтарч Бодлогын зөвлөмж гаргах хамтарсан ажлын хэсэг байгуулаад байна. Тус ажлын хэсэг нь төслийн кейс судалгааг ашиглан уул уурхайн нийгмийн нөлөөллийн үнэлгээ, нөхөн олговрын болон малчдын эрхийн талаарх шинэ бодлогыг боловсруулж, газрын тухай шинэ хууль баталж хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Киргизстан улсын хувьд төслийн хүрээнд хийгдсэн уул уурхайн зөрчил, мөргөлдөөний талаарх хээрийн судалгааны ажлын үр дүнг тус улсын ЗГ-аас санаачилан хэрэгжүүлж буй уул уурхайн салбарын мэдээллийг ил тод, нээлттэй болгох үйл ажиллагаанд ашиглаж байна.

Судалгааны үр дүнд Киргизстаны хөдөө орон нутгийн иргэд уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг олж авах (нөөцийн хэмжээ, ашигт малтмал олборлох, боловсруулах, экспортлох, хөдөлмөр эрхлэх боломж, байгаль орчин, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, ашиглалтын лиценз олгох, нөхөн сэргээлтийн тухай хууль тогтоомж) боломжтой болсон юм. Төслийн энэхүү хувь нэмэрийг Киргизстаны Засгийн Газар өндрөөр үнэлж Төв Азийн Их Сургуульд (<https://ucentralasia.org/Resources/Item/2499/EN>) Киргизстаны Түнш шагналыг гардуулсан юм.

Түүнчлэн төслийн хүрээнд Монгол Улсад найман удаагийн, Киргизстанд хоёр удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулаад байна. Эдгээр сургалтанд Монгол, Киргизстан, Афганистан улсын их, дээд сургуулийн оюутнууд, эрдэмтэн судлаачид, хараат бус судлаачид, ТББ-ын албан хаагчид, төрийн албан хаагчид хамрагдлаа. Сургалтууд нь чанарын судалгааны аргууд, эрдэм шинжилгээний ажил бичих, чанарын мэдээллийг кодлох, дүн шинжилгээ хийх, судалгааны ёс зүй, судалгааны төсөлт тэтгэлэгт хамрагдах зэрэг сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан.

Мөн Монгол Улсад уул уурхайн салбарт тулгарч буй бэрхшээл, боломжийг хэлэлцэх, нотолгоонд суурилсан шилдэг туршлагыг бий болгох зорилгоор мэдлэг солилцох цуврал арга хэмжээнүүдийг зохион байгуулаад байна. Эдгээр цуврал уулзалтуудад уул уурхайн компаниуд, засгийн газрын яамдын төлөөлөгчид, хуулийн фирмүүд, ТББ-уудын төлөөллийг оролцуулав. Төслийн баг болон Хил хязгааргүй Алхам ТББ-аас зохион байгуулсан нөхөн олговрын талаарх хэлэлцүүлэг нь нөлөөллийн бүсийн малчин ард иргэд, уул уурхайн компаниуд, орон нутгийн засаг захиргаа, үндэсний хууль тогтоогчдын хоорондын яриа хэлэлцээг идэвхжүүлсэн явдал байв.

## **ХЭВЛЭГДСЭН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЛЭГҮҮД:**

Lezak S, Ahearn A, McConnell F, Sternberg T. (2019). Frameworks for conflict mediation in international infrastructure development: A comparative overview and critical appraisal. *Journal of Cleaner Production*, doi: 10.1016/j.jclepro.2019.118099

Sternberg T, Ahearn A, McConnell F. (2019). From conflict to a Community Development Agreement: a South Gobi solution. *Community Development Journal*, doi: 10.1093/cdj/bsz018

# УЛААНБААТАР ХОТ РУУ ЧИГЛЭСЭН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БҮРТГЭЛИЙН ХЯЗГААРЛАЛТ БОЛОН ШИЛЖИН ИРЭГСДИЙН ЭМЗЭГ БАЙДАЛД ҮЗҮҮЛСЭН ҮР НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА



Эх сурвалж: "Нүүдэл-2017" хаврын анхны фототур, Монголын хэвлэлийн агентлаг, 2017

## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

2017 онд хөдөө, орон нутгаас нийслэлд байнга оршин суухаар ирэх иргэдийн шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай Нийслэлийн засаг даргын А/17 тоот захирамж гарсан. Энэхүү судалгаа нь дотоод шилжих хөдөлгөөний хязгаарлалтын болон шилжин ирэгсдийн эмзэг байдалд үзүүлж буй үр нөлөөг үнэлэх үндсэн зорилготой. Үнэлгээний үр дүнд үндэслэн дотоод шилжилт хөдөлгөөний цаашдын чиг хандлага болон шилжин ирэгсдийн эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн бодлогын зөвлөмж гарах юм. Уг судалгааны хүрээнд дараах гол асуултуудад хариулахыг зорьж байна. Үүнд:

1. Нийслэл рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хязгаарласнаар шилжин ирэгсдийн тоо бодитоор буурсан уу?
2. Бүртгэлийн хязгаарлалт хэрэгжих хугацаанд нийслэлд шилжин ирэгсдийн эмзэг байдалд уг хязгаарлалт хэрхэн нөлөөлсөн бэ?
3. Бүртгэлийн хязгаарлалт нь нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэд хувь нэмэр оруулсан уу?
4. Нийслэл рүү чиглэсэн шилжих хөдөлгөөн болон шилжин ирэгсдийн эмзэг байдлыг бууруулахад цаашид ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ?



# 2020

1-р сарын 20

# 2020

6-р сарын 30

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хот



## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын дотоод шилжих хөдөлгөөн, тэр дундаа хөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөнд ардчилсан хувьсгал, нийт улс орныг хамарсан олон удаагийн зуд, уур амьсгалын өөрчлөлт, хөдөө орон нутаг дахь нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж, амьдралын баталгаа, эдийн засгийн нөхцөл байдал зэрэг олон хүчин зүйл нөлөөлсөөр ирсэн. 2005 оноос хойш Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн тоо тогтмол, тасралтгүй өсөж байсан бөгөөд 2017 оныг хүртэл жилд дунджаар 30,000 иргэн нийслэлд шилжин суурьшсан байна.

Статистикаас харахад хөдөө, орон нутгаас шилжин ирэгсдийн дийлэнх хувь нь УБ хотын хамгийн их хүн ам бүхий Сонгинохайрхан, Баянзүрх зэрэг захын дүүргүүдийн гэр хорооллын бүсэд суурьшдаг аж. Шилжин ирэгсдийн өсөлтөөс үүдэн тухайн дүүрэг, хорооны нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж хомсдох, чанар буурах, орчны бохирдол ихсэх зэрэг сөрөг үр дагавруудтай нийслэлийн иргэд нүүр тулдаг байна.

2017 оны 1 сард Нийслэлийн засаг дарга “Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” захирамжийг гаргасан. Уг захирамжийн дагуу 2020 оны 1 сар хүртэл хөдөө орон нутгаас нийслэл хотод байнга оршин суухаар шилжин ирэх хөдөлгөөнийг зогсоосон. Иймд Нийслэлийн ЗД-ын уг захирамжийн хэрэгжилт, шилжин ирэгсдийн эмзэг байдалд үзүүлсэн нөлөө, МУ-ын дотоод шилжих хөдөлгөөнд гарсан өөрчлөлт зэргийг үнэлэх хэрэгцээнээс үүдэн төсөл хэрэгжиж эхэлсэн.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Үнэлгээг хийхдээ тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулсан холимог аргыг ашиглана. Тоон судалгааны хүрээнд хоёрдогч эх үүсвэрийн тоон мэдээлэлд үндэслэн бүртгэлийн хязгаарлалтын үед нийслэлд шилжин ирсэн бүртгэлгүй иргэдийн тоог статистик шинжилгээний аргаар үнэлж, тооцно. Түүнчлэн бүртгэлийн хязгаарлалт тогтоохоос өмнөх болон хэрэгжиж эхэлсний дараа нийслэлд шилжин ирсэн нийт 800 орчим иргэнийг хамруулж асуумж судалгааны аргаар мэдээлэл цуглуулна. Энэхүү судалгаагаар бүртгэлийн хязгаарлалт шилжин ирэгсдийн эмзэг байдалд хэрхэн нөлөөлснийг тодорхойлно.

Харин чанарын хүрээнд шилжин ирсэн иргэдтэй бүлгийн ярилцлага хийх, төслийн оролцогч талууд болох Улсын бүртгэлийн ерөнхий газар, НЗДТГ, дүүрэг, хороодын албан хаагчидтай гүнзгийрүүлсэн ярилцлага хийх төлөвлөгөөтэй байна. Төслийн арга зүй одоогоор боловсруулагдаж байгаа бөгөөд хараахан эцэслэгдээгүй байгааг дурдах нь зүйтэй юм.

## ҮР ДҮН, ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Энэхүү төсөл нь жилийн тайлан гарах явцад хэрэгжиж байсан ба 2020 оны 6 сард үр дүн, дүгнэлт эцэслэгдэх тул энэ хэсэгт одоогийн байдлаар ямар нэгэн мэдээлэл оруулах боломжгүй байна.

## “АМЬСГАЛАХ ЭРХ” ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ



### ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Пийпл Ин Нийд (ПИН) ТББ

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Улаанбаатар хот болон Архангай аймагт агаарын бохирдлын мэдээлэл, үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлж мэдээллийн хүртээмжтэй системийг бий болгох зорилготойгоор хэрэгжсэн “Амьсгалах Эрх” төслийн хэрэгжилтийг үнэлж, үнэлгээний үр дүнд үндэслэн төслийг сайжруулах санал зөвлөмж боловсруулах үндсэн зорилготой.





# 2020

1-р сар

# 2020

5-р сар

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хотын 5 дүүрэг, Архангай аймгийн Цэцэрлэг сум

### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Улаанбаатар хот өвлийн улиралд ДЭМБ-ын зөвшөөрөгдөх хэмжээг даруй 50 дахин давсан агаарын чанартай байдаг тул дэлхийд агаарын бохирдлоор тэргүүлэгч хотуудын нэгд зүй ёсоор тооцогдож байна. Нийслэлээс гадна аймаг, сумын төв гэх мэт суурин газруудад ч агаарын бохирдлын асуудал хурцаар тавигдаж байна. Агаарын бохирдол нийт хүн амын дунд амьсгалын замын өвчлөл, зүрх судас, уушгины хавдрын өвчлөл үүсэх, нялхсын эндэгдэл,

зулбалт, ургийн гаж хөгжлийг ихэсгэх зэрэг нөлөө үзүүлж нийгмийн эрүүл мэндэд сөрөг үр дагавар авчирч байна.

Үүнтэй холбоотойгоор Амьсгалах Эрх төслийг ПИН ТББ санаачлан Европын Холбоо болон АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран 2018 оны 1 сараас 2019 оны 12 сар хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн. Төслийг дараах үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн дагуу үйл ажиллагаа зохион байгуулсан байна.

Дүрс 3. “Амьсгалах Эрх” төслийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд



Манай байгууллагын хувьд Амьсгалах Эрх төсөл үндсэн зорилго зорилтдоо хүрсэн эсэх, төслийн урт хугацааны нөлөөлөл, дээр дурдсан үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, авсан арга хэмжээний хэрэгжилт, оролцогч талуудын оролцооны түвшин зэргийг үнэлж төслийн чанар, нөлөөллийг сайжруулах, цаашид авах арга хэмжээ зэргийг тусгасан санал зөвлөмж боловсруулах үүргийг гүйцэтгэж байна.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Арга зүйн хувьд төслийн хэрэгжилтийг хагас бүтэцчилэгсдэн болон гүнзгийрүүлсэн ярилцлага, баримт бичгийн шинжилгээ зэрэг багтсан Чанарын, төслийн оролцогч талуудаас асуумжид үндэслэн мэдээлэл цуглуулах Тоон аргыг хослуулсан холимог аргаар үнэлнэ. Үнэлгээний төслийн ерөнхий дизайныг гаргахдаа Амьсгалах Эрх төслийн логик хүрээнд үндэслэн Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Хөгжлийн тусламжийн хорооны үнэлгээний доорх 5 хүрээний дагуу шалгуур үзүүлэлтүүд боловсруулсан.

Дүрс 4. ОУ-ын ЭЗХАХБ-ын Хөгжлийн тусламжийн хорооны үнэлгээний хүрээ



## ҮР ДҮН, ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Энэхүү төсөл нь жилийн тайлан гарах явцад хэрэгжиж байсан ба 2019 оны 5 сард үр дүн, дүгнэлт эцэслэгдэх тул энэ хэсэгт ямар нэгэн мэдээлэл оруулах боломжгүй байна.

# “ГҮҮД НЕЙБОРС МОНГОЛ” ОУТББ-ЫН БАЙГУУЛЛАГЫН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

“Гүүд нейборс Монгол” ОУТББ

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

‘Гүүд Нэйборс Монгол’ ОУТББ байгууллагын таван жилийн стратеги (2020-2025) боловсруулахад ашиглагдах байгууллагын гадаад, дотоод орчны шинжилгээг хийж, байгууллагын удирдлагыг шийдвэр гаргахад шаардлагатай суурь мэдээллээр хангах зорилготой.



2020 1-р сар

2020 4-р сар

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

- Улаанбаатар хотын 6 дүүрэг
- Дархан аймгийн Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн төлөөллүүд



## СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

‘Гүүд Нэйборс Монгол’ ОУТББ-ын 2015-2019 онд хэрэгжүүлсэн стратегийн төлөвлөгөөний хугацаа дуусаж буйтай холбоотойгоор дараагийн таван жилийн хугацаанд баримтлах стратегийн төлөвлөгөөг боловсруулах хэрэгцээ шаардлага үүссэн. 2020-2025 оны хооронд баримтлах стратегийн төлөвлөгөөг боловсруулахад байгууллагын гадаад болон дотоод орчны шинжилгээг гүйцэтгэж, дараагийн стратегийн төлөвлөгөө боловсруулах “Гүүд нейборс Монгол” ОУТББ-ын багийг шийдвэр гаргах суурь мэдээллээр хангах зорилгоор тус судалгааны ажлыг гүйцэтгэж байна.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Байгууллагын гадаад орчныг PESTLE шинжилгээний аргачлалыг ашиглан баримт бичгийн судалгааны аргад үндэслэн гүйцэтгэж байна. Энэ хүрээнд доор дурдсан орчны хүрээнд “Гүүд Нейборс Монгол” ОУТББ-ын цаашдын үйл ажиллагаанд боломж болон эрсдэл болохуйц хүчин зүйлүүдэд шинжилгээ хийж байна. Үүнд:

- Улс төр ба бодлого (Political)
- Эдийн засаг-(Economic)
- Нийгэм-соёл-(Socio-Culture)
- Технологи-(Technological)
- Хууль эрхзүй-(Legal)

- Хүрээлэн буй орчин-(Environment)

Байгууллагын дотоод орчныг судлахдаа SWOR шинжилгээний аргачлалыг ашиглан баримт бичгийн судалгаа болон байгууллагын үр шим хүртэгч, харилцагч байгууллагууд, албан хаагч, удирдлагын түвшнээс цуглуулсан чанарын мэдээлэлд үндэслэн доор дурдсан агуулгын хүрээнд шинжилж байна:


- Байгууллагын давуу тал (Strength)
- Байгууллагын сул тал-(Weakness)
- Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах дотоод боломж-(Opportunity)
- Байгууллагын дотоод нөхцөлд тулгарч буй эрсдэл-(Risk)

## ҮР ДҮН, ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Гадаад болон дотоод орчны шинжилгээний бүрэн зураглалыг гаргасны дараа үр дүнд үндэслэн байгууллагын дараагийн шатны стратеги төлөвлөгөөнд санал болгох шийдэл, алхмуудыг тодорхойлохоор IRIM судалгааны хүрээлэнгийн баг ажиллаж байна.

Тус судалгааны үр дүн нь байгууллагын дотоод нууцад хамаарах мэдээлэл агуулж буй тул шинжилгээний үр дүнтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг харуулах боломжгүй байна.

# МОНГОЛ УЛСАД НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ЭЦСИЙН ШАТНЫ ҮНЭЛГЭЭ



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Дэлхийн Банк (ДБ) болон Швейцарийн Хөгжлийн Агентлаг (ШХА)

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү эцсийн шатны үнэлгээний зорилго нь МУ-д Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх (МУНЭХБ) төслийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх явдал юм. IRIM судалгааны хүрээлэн 2016 онд МУНЭХБ төслийн суурь судалгааг гүйцэтгэсэн бөгөөд эцсийн шатны үнэлгээг хийхдээ суурь судалгаатай уялдуулж аргагүй, түүврийн хувьд нийцүүлж, харьцуулагдахуйц байдлаар гүйцэтгэлээ.



# 2019


11-р сар

# 2020

4-р сар

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хот, Увс,  
Ховд, Хөвсгөл, Дархан-  
Уул, Сэлэнгэ, Өвөрхангай,  
Говьсүмбэр, Хэнтий,  
Дорнод аймаг



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

МУНЭХБ төсөл нь ШХА ба ДБ-ны -санхүүжилтээр 2015-2019 онд нийт 10 аймаг болон Улаанбаатар хотын 3 дүүрэгт хэрэгжсэн. Төслийн үндсэн зорилго нь ядуурал ихтэй орон нутагт амьдарч байгаа иргэд нийгмийн эгэх хариуцлагын тусламжтайгаар төрийн шийдвэр гаргах үйл явцад оролцохын зэрэгцээ чанартай үйлчилгээ авах боломжоор хангагдах явдал юм. Тодруулбал, улсын нөөцийн үр нөлөөтэй, ил тод байдлыг дээшлүүлэх болон хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх юм.

МУНЭХБТ төсөл нь дараах үр дүнд хүрэхээр зорин ажилласан. Үүнд:

- Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх хүрээнд иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн бүлгүүд, бусад оролцогчид чадавхиж, нийгмийн эгэх хариуцлагын үр дүнтэй арга хэрэгслүүд, стратеги болон нөөцийг өргөжүүлнэ.
- Нийгмийн эгэх хариуцлага нь үндэсний болон нутгийн түвшинд үр нөлөөтэй, албажин, тогтвортой байдлаар төлөвшин зохион байгуулагдана (Мэдээллийн нээлттэй байдал, иргэдийн оролцоо, хариу арга хэмжээ авах гэх мэт).

### ТӨСЛИЙН ДИЗАЙН

Тоон ба чанарын судалгааны аргыг хослуулан эцсийн үнэлгээг хийсэн бөгөөд төсөл хэрэгжсэн 8 аймаг, 3 дүүргийг үнэлгээнд хамрууллаа. Үнэлгээний мэдээллийг дараах аргуудаар цуглууллаа. н. Үүнд:

- Асуумж – 1000 гаруй өрх болон Монгол улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудын төлөөлөл
- Ярилцлага - ТББ, бодлогын хүрээлэн, төрийн байгууллагын ажилтнууд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөл
- Бүлгийн ярилцлага – Төслийн оролцогч талууд буюу ИНБ-ууд
- Баримт бичгийн судалгаа - Холбогдох ном, судалгааны баримт бичгийн судалгаа

Төслийн үр дүнг суурь судалгааны мэдээлэл болон хяналтын бүлэгтэй харьцуулан шинжилж, үр дүнг боловсруулж байна.

### ҮР ДҮН, ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Энэхүү төслийн үр дүн жилийн тайлан гарах явцад хараахан боловсруулж дуусаагүй байсан ба 2020 оны 5 сар гэхэд үнэлгээний тайлан МУНЭХБ төслийн албан ёсны цахим хуудсанд нийтлэгдэнэ.